

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
БИЕЛЭЛТ

/2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

УЛААНБААТАР ХОТ
2017 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР**

2017.12.28

№	Агуулга	Зорилтын тоо	Хэрэгжилтийн явц					Хувь %
			100	70	40	0	Үнэлэх боломжгүй	
1	ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ - НИЙГМИЙН ХӨГЖИЛ	16	-	2	14	-	-	43,75
2	ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	19	-	2	17	-	-	43,16
3	ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	10	-	1	9	-	-	43,0
4	ЖАРГАЛТАЙ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ	5	-	1	4	-	-	46,0
5	ЖАРГАЛТАЙ ИРГЭН - НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ	14	-	-	14	-	-	40,0
Дүн		64	-	6	58	-	-	42,82

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Хүрсэн түвшин хэрэгжилт	Хэрэг жил тийн хувь
НЭГ. ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ-НИЙГМИЙН ХӨГЖИЛ			
1.1 ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ			
1	<p>1.1.1 Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, иргэний бүртгэл мэдээллийн технологийг боловсронгуй болгох “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтэн нийт 74 хүнээс хөтөлбөрт тусгах саналыг авч тусган, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлуулж 6 бүлэг 56 хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнан “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан. Хөтөлбөрийн хүрээнд Улсын төсвөөс 24,0 сая, нийслэлийн төсвөөс 834,6 сая, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс 296,0 сая, дүүргийн төсвөөс 777,0 сая, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөөв 50,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан ажиллаж, эмч, ажилтнуудыг чадваржуулахад 78,2 сая төгрөг зарцуулсан байна. Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэгдсэн шилэн кабелийн сүлжээнд холбож, E-Health нэгдсэн цахим програм хангамжийг бүрэн нэвтрүүллээ. Ингэснээр иргэдэд эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатлалын үйлчилгээ чирэгдэлгүй хүрэх боломж нээгдэж байгаа бөгөөд ЭМТ-ийн үзлэгийн цагийг ӨЭМТ-өөс өдөр тутам захиалах, үйлчлүүлсэн иргэдийн цахим сан бүрдэж өвчлөлийн түүх буюу сторыг харах боломжтой болж байна. Мөн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, эмнэлэг хөдөлмөрийн хяналтын комиссын хурлын ерөөг тохижуулж өндөр хурдны интернетийн сүлжээнд холбон алсын зайн хурал хийх, эрчимт эмчилгээний ерөөг сахиурын ерөөтэй холбож 5 минут тутамд үйлчлүүлэгчийн биеийн байдлыг ар гэрийнхэнд нь автоматаар мэдээлж шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр иргэд өөрийн хорооны Өрхийн эрүүл мэндийн төвөөс хуралд оролцдог болоод байна. Энэ ажлаараа Нийслэлийн “Сайн туршлага-2017”-д бүртгүүлж гэрчилгээ авсан.</p>	70
2	<p>1.1.2 Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг барихад хамтран ажиллана.</p>	<p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй яаралтай түргэн тусламжийн төвийн барилгыг Хайлаастын 12 дугаар гудамжны 203, 204 тоот хоёр иргэний газрыг нөхөн олговороор авч бүрэн чөлөөлсөн бөгөөд барилгын ажлыг ирэх хавар эхлүүлэхээр болсон. Одоогоор холболтын зураг хийгдэж хяналтын шатанд явагдаж байна. Дүүргийн хүүхдийн эмнэлгийн барилгын эскиз зургийг дүүргийн Хайлааст хэсэгт Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх “Асар-Өргөө Консалтинг” ХХК боловсруулсан боловч ямар нэгэн шийдвэр гараагүй. Амбулатори-2 буюу Хайлааст салбарын барилгын зураг</p>	40

		төсвийн ажил хийгдэж байна. Мөн Нийслэлийн төсвийн 76,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн бага тойруу салбарыг засварлан мэс заслын тасаг шинээр байгуулж 133,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган мэс заслын 2 эмч, гэмтлийн 2 эмч, 4 сувилагчтайгаар үйл ажиллагааг эхлүүлээд байна.	
3	1.1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд 841 удаагийн сургалт, сурталчилгааны ажилд давхардсан тоогоор 30100 гаруй хүнийг хамруулж, 341 төрлийн давхардсан тоогоор 75900 ширхэг сурталчилгааны материал тараасан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн өдөрлөгийг 70 удаа зохион байгуулж нийт 34166 хүнийг хамруулж, 38 удаагийн аянд давхардсан тоогоор 19398 хүнийг хамруулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн байна. Мөн өсвөр насны охид, хөвгүүдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 11 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 13865 хүүхэд өсвөр үеийнхэн хамруулсан нь өмнөх оны мөн үеийн түвшингээс 5,2 хувиар ахисан үзүүлэлттэй байна. “Бидний Ирээдүй хүчирхэг охид” сэдэвт охидын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх өдөрлөг зохион байгуулж нийт 180 охидыг хамруулсан. 57, 37, 49-р сургуулийн төгсөх ангийн 236 хүүхдэд “Архи тамхи мансууруулах бодисоос хэрхэн сэргийлэх, түүний хор уршиг” сэдвээр тус бүр 2 цагийн мэдээлэл, харилцан ярилцлага хийсэн бол 5, 50, 24, 23, 57, 61, 37, 39, 49-р сургуулийн ахлах ангийн сурагчдад “Эрүүл амьдралын зөв зан үйлд хандуулах бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж нийт 1294 өсвөр үеийнхэнийг хамрууллаа. Мөн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох нь” аяны хүрээнд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хайлааст болон Чингэлтэй ОНХХ-тэй хамтран 200 гаруй хүүхдээс санамсаргүй түүврийн аргаар асуумж авч, танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгууллаа. Дэлхийн тамхины эсрэг өдрийг угтан “Өсвөр үеийнхний эрсдэлт зан үйл” сэдэвт сургалтыг дүүргийн ерөнхий боловсролын 37, 17, 49, 117, 72-р сургуулийн “Эмч бүлгэм”-ийн 30 сурагчдад зохион байгуулж сургагч багшаар бэлтгэлээ. Сургагч багш, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэйгээ хамтран “Дэлхийн тамхигүй өдөр”, “Тамхинд үгүй гэж хэлье” уриатайгаар өдөрлөг зохион байгуулж 700 гаруй сурагчдыг хамруулсан байна. Мөн 117, 17, 37, 49, 72-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрт жирэмслэлтээс сэргийлэх нь” сэдэвт 1 сарын аяны хүрээнд сургалт зохион байгуулж нийт 1044 сурагчдыг хамруулсан.	40
4	1.1.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд Ахмадын 6 төрөлт тэмцээн зохион байгуулж 95 байгууллагын 948 тамирчин, Залуучуудын 6 төрөлт тэмцээн зохион байгуулж 59 байгууллагын 529 тамирчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 11 байгууллагын 37 тамирчин, төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагын дунд 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 79 байгууллагын 1500 тамирчин хамрагдлаа. Нийт 32 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 390 байгууллагын 20549 иргэдийг хамрууллаа. Дүүргийн Засаг даргын 2017 оны 173 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын байранд хийж хэвшүүлэх дасгалын сургалтыг хэлтэс албад хороодын 35 байгууллагын 390 ажилтан албан хаагчдад хийж хэвшүүлэн ажиллаж байна. Мөн сурагчдын завсарлагаанаар хийж хэвшүүлэх дасгалыг дүүргийн ЕБС-ийн биеийн тамирын багш, сурагчдад хийж хэвшүүлэн ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Улаанбаатар марафон 2017 олон улсын гүйлтэнд 82 байгууллагын 5704 иргэнийг хамруулж багийн дүнгээр 1 дүгээр байранд шалгарлаа. Монгол	40

		Улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлигаар ББХЧТТСорил авах ажилд 83 байгууллагын 11631 иргэдийг хамруулаад байна.	
5	1.1.5 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулан, Залуучуудын шигшээ багийг хөгжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 13 төрлөөр хичээллүүлж, шигшээ багуудын дасгалжуулагч нартай гэрээ байгуулан, шигшээ багуудын тамирчдын бэлтгэл сургуулилт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж ажилласны үр дүнд тайлант хугацаанд нийт 65 удаагийн тэмцээнд оролцож Нэрэмжит тэмцээнээс 26 алт 24 мөнгө 26 хүрэл медаль, Хотын аварга шалгаруулах тэмцээнээс 16 алт 13 мөнгө 120 хүрэл медаль, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 11 алт 8 мөнгө 19 хүрэл медаль, Олон улсын тэмцээнээс 24 алт 17 мөнгө 19 хүрэл медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт 3 мөнгө 2 хүрэл медаль, нийт 249 медаль хүртсэн амжилттай байна.	40
6	1.1.6 Дүүрэгт баригдаж буй 1000 хүний суудалтай спорт цогцолбор, 61 дүгээр сургуулийн спорт заалны ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	Дүүргийн усан бассейн мөсөн гулгуурын талбай бүхий 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2017 оны улсын төсөвт 1 тэрбум төгрөг батлагдаж, барилгын гүйцэтгэгч компанийн дансанд шилжин орсноор барилгын техникийн нөхцөлүүдийг шинэчлэн гаргуулж, А блокын 4, 5 давхарын карказ цутгалтын ажил хийгдэж байна. В, С блокын ажил бүрэн хийгдэж дууссан. 61 дүгээр сургуулийн биеийн тамирын заалны барилгын одоогийн ажлын гүйцэтгэлд яамны ажлын хэсэг ажиллаж үнэлгээ хийж, барилга угсралтын ажилд технологийн алдаа, дутагдал гарсаныг тогтоон дахин засварлах дүгнэлт гаргасны дагуу засварын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2018 онд ашиглалтад оруулахаар болсон.	40
1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ			
7	1.2.1 Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх "Жаргалтай үрс" төслийг хэрэгжүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх "Жаргалтай үрс" төслийг боловсрууллаа. Тус төслийн хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороонд баригдсан 245 дугаар цэцэрлэг, 16 дугаар хороонд баригдсан 246 дугаар цэцэрлэг, 18 дугаар хороонд баригдсан 247 дугаар цэцэрлэг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хороонд баригдсан 139 дүгээр бага сургууль, 221 дүгээр цэцэрлэг, 17 дугаар хороонд баригдсан 140 дүгээр бага сургууль, 222 дугаар цэцэрлэг, 83 дугаар цэцэрлэгийн 240 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын ажил, дүүргийн төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 70 дугаар цэцэрлэгт 2 нэмэлт бүлэг, 300,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 126 дугаар цэцэрлэгт 4 нэмэлт бүлгийн байрыг тус тус ашиглалтад оруулж 1277 хүүхдийг хамруулж цэцэрлэгийн хамран сургалтыг 8,2 хувиар нэмэгдүүлсэн байна. Мөн дүүргийн төсвийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 дугаар цэцэрлэгийг 240 хүүхдийн ортойгоор шинэчлэн барих, нийслэлийн төсвийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 19 дүгээр цэцэрлэгийн 150 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын цутгалтын ажил хийгдэж, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан ажил зогсоод байна.	40
8	1.2.2 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх "Чингэлтэйн боловсрол" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Чингэлтэйн боловсрол-2020" хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 29 дүгээр тогтоолоор батлуулж 5 бүлэг 26 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнан Бүрэн хангалттай үнэлгээ авсан. Хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн төсвөөс 5158,6 сая, дүүргийн	70

	хэрэгжүүлнэ.	төсвөөс 2623,3 сая, бусад эх үүсвэрээс 358,1 сая нийт 8140,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалталт татсан бөгөөд багш, суралцагчийн хөгжлийг хангах, дэмжин урамшуулахад 332,2 сая төгрөг зарцууллаа. Дүүргийн ИТХ-ын 2016 оны 23 дугаар тогтоолын дагуу “Сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа”-ны чанар, хүртээмж, хүүхэд нэг бүрийн Сурлага-Хөгжил-Төлөвшилтийн ахиц, амжилтаар үнэлэн шалгаруулж 35 багшид тус бүр 500.000 төгрөгийн урамшуулал олгосон бол хүнд нөхцөлд амьдарч буй тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай 7 багшид гэр 12 багшид мөнгөн тусламж нийт 19 багшид тусламж дэмжлэг үзүүлэх журмын дагуу 25,5 сая төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Мөн “Өв тэгш бүтээлч Монгол хүүхэд” төлөвшүүлэх зорилтын хүрээнд 5 удаагийн уралдаан тэмцээн, 3 удаагийн төсөлт ажил, 3 удаагийн аяныг зарлан хэрэгжүүлж нийт сурагчдыг хамруулсан бол багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн “Түншлэл” зорилтот төслийг амжилттай хэрэгжүүллээ.	
9	1.2.3 Орон нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан дүүргийн нутаг дэвсгэрт Соёлын ордон байгуулж, соёлын төвийн үйл ажиллагааг дэмжинэ.	Дүүргийн соёлын төвийн үйл ажиллагааг дэмжин материаллаг баазыг нэмэгдүүлэх хүрээнд дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгөөр автомашин, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Хүүхэд залуусын авьяас билгийг нээн хөгжүүлэх, иргэдэд соёл урлагаар үйлчлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон, үр ашигтайгаар өнгөрүүлэх зорилгоор дуу хөгжим, морин хуур болон бүжгийн дугуйланг хичээллүүлж давхардсан тоогоор нийт 113 хүүхэд суралцаж байна. “Даншиг наадам-Хүрээ цам 2017” шашин, соёлын арга хэмжээнд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урд хаалган дээр нийслэлийн 9 дүүргийн ардын авьяастнуудын “Монголын гайхамшигт урлаг” тоглолтыг Нийслэлийн Соёл урлагийн газраас хоёр өдрийн турш зохион байгууллаа. Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Төгөлдөр урлаг ТББ-тай хамтран зохион байгуулсан Олон улсын ахмад ардын авьяастнуудын “Эгшиглэнт аялгуу” ардын урлагийн наадам Нийслэлийн Улаанбаатар чуулгын концертын танхимд болсон. Тус наадамд Монгол, Өвөр Монголын 10 гаруй хамтлагийн 300 гаруй уран бүтээлчид ур чадвар, авьяас билгээрээ өрсөлдсөн бөгөөд дүүргийн Соёлын төвийн дэргэдэх “Дөрвөн цаг” хамтлагийн уран бүтээлчид гоцлол хөгжим, хамтлаг хөгжим, гоцлол дуу, гоцлол бүжиг, хоршил бүжиг, хамтлаг бүжиг, язгуур урлаг гэсэн төрлүүдэд оролцож 10 алт 2 хүрэл медаль хүртэж, нийлбэр дүнгээр “Шилдгийн шилдэг” хамтлагаар шалгарлаа.	40
10	1.2.4 Иргэдийн хөгжлийг бүх талаар дэмжсэн “Хотын иргэн-хотын соёл” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Хотын иргэн-хотын соёл” хөтөлбөрийг боловсруулж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 26 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлууллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд Соёл урлаг, спорт, соён гэгээрүүлэх чиглэлээр 90 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 535.3 сая төгрөг зарцууллаа. Хүүхдийн номын өргөөгөөр сургуулийн өмнөх болон ЕБС-ийн нийт 21000 хүүхэд үйлчлүүлсэн. Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх чиглэлээр “Үлгэрийн цаг”, “Би хэн бэ?” уулзалт чөлөөт ярилцлагын цаг, “Би Монгол хүн” уулзалт, “Шинжлэх ухаан танин мэдэхүйн кино цаг”, “Зохиолч-Уншигчдын уулзалт” зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж давхардсан тоогоор 15000 гаруй хүүхэд багачууд хамрагдлаа. Мөн соёл, спортын олон улсын 15 удаагийн уралдаан тэмцээнүүдэд 60 гаруй иргэд, хүүхэд багачуудыг оролцуулан дэмжин ажилласан.	40
11	1.2.5 Залуучууд, өсвөр үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн	“Залуучуудын өдөр”-өөр дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд “Залуучуудын хөгжлийн төв”-ийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Тус төв нь	40

	“Хөгжлийн төв” байгуулж, олон талт үйл ажиллагаа явуулна.	залуучуудад амьдрах ухааны сургалт явуулах танхим, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө, компьютерийн өрөө, номын сан, шатар даам тоглох танхим зэрэг залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих боломжтой байхаар тохижуулагдаж, интернэт орчин, тоног төхөөрөмж, ном, гарын авлагаар иж бүрэн хангагдсан. Өсвөр үе залуучуудыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, гэр бүл, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр 10 гаруй сургалт, үйл ажиллагаагаар 2000 гаруй залуучуудыг хамруулан ажилласан байна.	
1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ			
12	1.3.1 Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг дэмжин ажиллаж, төсөл хөтөлбөрийн хүрээнд “Ахмадын асаргаа сувилгаа”-ны төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Ногоон булан дахь Ахмадын амралт сувилал нь НХЕГазраас зарласан тендерт оролцож, 400 ахмад хүлээн авах эрх авсан. 2017 оны байдлаар 200 гаруй ахмадыг амраасан ба мөн дүүргийнхээ хороод, ахмадын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус амралтын газар нь тайлант хугацаанд нийт 60 гаруй сая төгрөгийн орлоготой ажилласан ба үйл ажиллагааныхаа орлогоор хөгжмийн заалны тоног төхөөрөмж, бялдаржуулах танхимын тоног төхөөрөмжийг нийт 7,2 сая төгрөгөөр шинэчилж, амралтын гэрүүдийн ор, зөөлөн эдлэлийн шинэчлэл хийсэн. Мөн дүүргийн төсвийн 3.0 сая төгрөгийн хөрөнгөөр уурын зуухны яндан, насос солих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн Цонжинболдог дахь амралтын газрын засвар тохижилтын ажлууд хийгдэж, иргэд, амрагчдыг хүлээн авахад бэлэн болоод байна.	40
13	1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Японы ОУ-ын JICA байгууллагатай хамтран төрийн болон үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээ, явган хүний гарц, гэрлэн дохио, замын уулзваруудын хүртээмжид үнэлгээ хийх Ажлын хэсэг байгуулагдан дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон харьяа хэлтэс, өрхийн эрүүл мэндийн төв, худалдааны төвүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. Дүүрэгт шинээр байгуулагдсан цэцэрлэгүүдийн орц гарц, ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан тохижуулсан бөгөөд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын 52,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 49 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөнүүдийг засварлан тохижуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг тусгайлан тохижууллаа.	40
14	1.3.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй, ил тод хүргэх чиглэлээр Нийгмийн халамжийн тэтгэвэрийг 2570 иргэнд 3.478.949.360 төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэмжийг 3053 иргэнд 1.791.104.710 төгрөг, Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 3017 иргэнд 1.371.612.180 төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 219 иргэнд 92.386.500 төгрөг, Ахмад настны тусламж, хөнгөлөлтийг 6315 ахмад настанд 1.572.795.680 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийг 2197 иргэнд 530.261.613 төгрөг, Алдар цолтой ахмад настанд төрөөс олгож буй мөнгөн тусламжийг 180 иргэнд 322.226.800 төгрөг, Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжийг 7080 эхэд 1.608.617.800 төгрөг, Алдарт эхийн одонгийн тэтгэмжийг 8532 эхэд 1.106.120.000 төгрөг, Насны хишгийг 6563 иргэнд 1.054.550.000 төгрөгийг тус тус олгосон.	40
15	1.3.4 Хүн амын хөгжлийг дэмжсэн гэр бүлд зөвлөн туслах, зорилтод бүлэг рүү чиглэсэн халамж	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зөвлөх үйлчилгээ арга хэмжээний хүрээнд нийт 37 төслийг хүлээн авснаас 6 төсөл сонгон шалгаруултад тэнцсэн. Эргэн төлөгдөх нөхцөлтэй	40

	<p>үйлчилгээг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлнэ.</p>	<p>санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд нийт 56 ахмад настан төсөл ирүүлнээс 22 төслийг сонгон шалгаруулж, 17,5 сая төгрөгийн дэмжлэг олгогдоод байгаа бол Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр ажлын байртай болох зорилготой иргэдэд зориулж жижиг зээлийн арга хэмжээний хүрээнд аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 10 сая хүртэл, аж ауйн нэгж, нөхөрлөл хоршоонд 20 сая хүртэлх төгрөгийн жижиг зээл олгох ажлыг Голомт банкттай хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллалаа. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 97 төсөлд 133,5 сая төгрөг, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 54 төсөлд 89,0 сая төгрөг, "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн 5 төсөлд 33,0 сая төгрөг, "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах арга хэмжээний 22 төсөлд 17,5 сая төгрөгийг тус тус олгосон бол дүүргийн төсвийн 283,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 30 цэгт ажлын байр бий болгон ажиллаж байна.</p>	
<p>16</p>	<p>1.3.5 Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, оюун ухаан, авъяас билэг, бие бялдар, ур чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 25 дугаар тогтоолоор 3 зорилтын хүрээнд 21 үйл ажиллагаа бүхий "Жаргалтай гэр бүл", хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хороо болон Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагналаа. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг хангах чиглэлээр 27 сургалтаар 2795, 7 тэмцээн уралдаанд 1327 хүүхдийг хамруулж, орон нутагт хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үрчлэлтэд хяналт тавих ажлын хэсгийн 13 удаагийн хуралдаанаар нийт 91 хүүхдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 19 сургалт, өдөрлөг, үйл ажиллагаанд 3000 гаруй иргэдийг хамруулан ажиллаж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох хороодын хамтарсан багийг чадваржуулах сургалт үйл ажиллагааг 7 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 379 хүнийг хамруулан ажиллалаа. Тус хөтөлбөрийн хүрээнд дүүргийн төсвөөс 116.841.000 төгрөг зарцуулсан.</p>	<p>40</p>
<p>ХОЁР: ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ</p>			
<p>2.1 ЭДИЙН ЗАСАГ</p>			
<p>17</p>	<p>2.1.1 Монгол Улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны "Төсвийн зарлагын хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай" 147 дугаар тогтоол, 2015 оны "Төсвийн зардлыг бууруулах тухай" 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагын санхүүжилтын эрх болон холбогдох зардлуудыг өдөр тутам үндсэн баримтаар хянан, гүйцэтгэлээр нь олгосон. 2017 оны батлагдсан төсөвт тусгагдсан гэрэл цахилгаан, халаалт дулаан, цэвэр бохир усны үнэ, тариф тооцооллын үндэслэлийг үндсэн нэгжид удирдамж өгч, шалган зааварчлах зохион байгуулалтын ажлууд хийгдсэн. Түлш, нүүрсээр халдаг хороодын цогцолбор байруудад шаталтын хувь өндөртэй нано болон бусад технологийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилго тавин судалгааны материалыг нэгтгэж, хороодын удирдлагуудад өөрийн хорооны бичиг хэрэг, хангамжийн материалын зардлын зарцуулах саналын эрхийг өгөх замаар тус зардлуудын хязгаарыг тогтоож үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах арга замыг нээлттэй болгосон. Дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч нэгтгэснээр төсвийн</p>	<p>40</p>

		<p>зардлыг бууруулах оновчтой аргыг олоход шаардлагатай судалгааны суурь баазыг нэмэгдүүлэх, зардал тус бүрээр нарийвчлах, оновчтой дүн шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дүүргийн хэмжээнд төсвөөс гаргаж байсан гар утасны зардлын санхүүжилтийг зогсоож, 1 өдөр явах авто машины шатахууны зардлыг 40 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тооцсон. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил үүргийн хуваарийг өөрчлөх замаар зохицуулалт хийн ажилласан. Мөн дээрх тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалж, цалин хөлсийг нэмэгдүүлэх болон төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг түр зогсоож, энэ талын шийдвэр гаргахгүйгээр ажилласан.</p>	
18	<p>2.1.2 Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тайлант хугацаанд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт 7,7 тэрбум төгрөг бүхий 92 ажлыг орон нутгийн өмчид бүртгэх байнгын Ажлын хэсэг хүлээн авч гүйцэтгэл тоо хэмжээг хянан шалгаж, холбогдох материалыг үндэслэн гэрээг дүгнэн холбогдох байгууллагын дансанд бүртгүүлж ажиллалаа. Дүүргийн 17 дугаар хорооны Ахуйн үйлчилгээний төвийн байрны ашиглалтыг хариуцуулах гэрээг дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй, 14 дүгээр хорооны Халуун ус ахуйн үйлчилгээний төвийн ашиглалтыг хариуцуулах гэрээг “Эхлэл” иргэдийн бүлэгтэй, 17 дугаар хорооны Олон нийтийн заалны ашиглалтыг хариуцуулах гэрээг иргэн Д.Отгонбаяртай, дүүргийн өмчийн арчлалт, хамгаалалтыг хариуцуулах гэрээг дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай тус тус байгуулан ажилласан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор шилжиж ирсэн “Амар тайван Чингэлтэй хөтөлбөр”-ийн хүрээнд суурилуулсан 284,9 сая төгрөгийн үнэ бүхий хяналтын камеруудыг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/81 дугаар тушаалаар, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-аас балансаас балансад шилжин ирсэн 506,8 сая төгрөгийн тээврийн хэрэгслүүдийг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/65 дугаар тушаалаар, Нийслэлийн төсвийн 172,6 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн хогийн сав хог ачих төхөөрөмжүүдийг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/72 дугаар тушаалаар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор 4,7 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус дүүргийн өмчид бүртгэн авч ажилласан. Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын А/406 дугаар тушаал, Эргэлтийн бус хөдөлгөөн хариуцсан комиссын 2017 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу 29,520,000 төгрөгийн зөөврийн ажлын байрыг дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес Инкубатор төвийн балансад шилжүүлэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/863 тоот Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай захирамжийг үндэслэн 1,390,871,595 төгрөгийн үнэ бүхий Нийслэлийн нутгийн захиргааны 3 дугаар байрны А корпусыг дүүргийн Засаг Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэн авч ажилласан.</p>	70
19	<p>2.1.3 Дүүргийн гадаад харилцаа,</p>	<p>Япон Улсын Шизуока мужийн Засаг дарга Кавакцу Хэйтагийн урилгаар дүүргийн Засаг дарга</p>	70

<p>хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Ж.Эрдэнэбат тэргүүтэй албаны хүмүүс 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 24-ний өдрүүдэд ажлын айлчлал хийсэн. Уг айлчлалаар тус мужийн хоттой шинээр хамтын ажиллагаагаа эхлүүлэн, цаашид боловсролын чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Манжуур хотын Ардын Их Хурлын дарга Го Цзин Мины урилгаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч Л.Баярсайхан тэргүүтэй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын хамтарсан ажлын хэсэг 2017 оны 04 дүгээр сарын 10-14-ны өдрүүдэд Манжуур хотод ажлын айлчлал хийсэн. Тус айлчлалын хүрээнд 7 дугаар сард болох БНХАУ-ын Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 14 дэх удаагийн үзэсгэлэнд дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах, Манжуур хотод “Чингэлтэйд үйлдвэрлэв төв”-ийг нээх талаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт яриа хэлэлцээрийг хийлээ. Айлчлалын хүрээнд Манжуур хотын их сургуулийн Оюутны парк хүлэмжийн ногоон байгууламж, төлөвлөлт, тохижилт, гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн технологи, стандарт, түүний арчлалт, хамгаалалт, Спортын цэцэрлэгт хүрээлэн, Манжуур хотын технологи дамжуулах олон улсын төв, жишиг хорооллын тохижилт зэрэгтэй танилцаж туршлага судалсан. Дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Сонам дүүргийн Мёнжи Олон улсын эрүүл мэндийн төвийн менежер Жей Шим нар Чингэлтэй дүүрэг, Мёнжи эмнэлэг хооронд хамтын ажиллагааны тогтолцоог байгуулж, харилцан дэмжлэг тусалцаа үзүүлэх, эмнэлгийн чанартай үйлчилгээг үзүүлэх зэргээр эмнэлгийн үйл ажиллагааны хөгжлийг эрэлхийлэх зорилготой санамж бичгийг үзэглэсэн. Тус хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дүүргийн Хүүхдийн амбулаторид Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Мёнжи эмнэлгээс нарийн мэргэжлийн эмч нарыг урьж авчран урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан. Мөн энэхүү санамж бичгийн хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 13-наас 17-ны өдрүүдэд дүүргийн 3 дугаар хорооны иргэн Ш.Анударь тус эмнэлэгт зүрхний тосгуур хоорондын таславчний цоорхойн мэс заслын хагалгаанд үнэ төлбөргүйгээр орж, мэс засал амжилттай болсон. ОХУ-ын Өвөр Байгалийн Их сургуультай 2017 оны 11 дүгээр сарын 17-нд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн заслын тусламж, боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан. Дүүргийн Засаг дарга БНСУ-ын Чоннам мужийн Пүрён хотын далайн бүтээгдэхүүний холбооны тэргүүн Чуй Юу Хан тэргүүтэй 11 төлөөлөгчдийг хүлээн авч, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах санал солилцов. Мөн Дүүргийн Засаг дарга Бүгд Найрамдах Унгар Улсын Монгол дахь Худалдааны төлөөлөгчийн газрын Ерөнхий захирал Ризак Шандор тэргүүтэй 3 төлөөлөгчдийг хүлээн авч, хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Тус санамж бичгийн хүрээнд хоёр тал дэд бүтэц, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, соёл боловсролын чиглэлээр хамтран ажиллах юм. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Олонлог сургуультай хамтран “Олон Улсын математикийн олимпиад”-ыг 2017 оны 12 дугаар сарын 22-ноос 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус олимпиадад ОХУ-ын БН Буриад Улсын Улаан-Үд хотын Советский дүүрэг, Казахстан Улсын Алма-Ата хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шилийн гол хот, Эрээн хотын нийт 17 багш сурагчид оролцов. Иран, Япон Улсын сурагчид онлайн цахим хэлбэрээр оролцсон юм.</p>
---	--

20	<p>2.1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэн, сонгон шалгаруулалтын ил тод байдал, иргэд олон нийтийн оролцоог хангана.</p>	<p>Цахим тендер шалгаруулалтын ажлын хүрээнд нийт 334 169 293 төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим хуудсаар зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудагт 2017 онд нийт 72 хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын нээлтийн мэдээ, 88 үр дүнгийн мэдээг байршуулсан байна. Мөн тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор ханган тендерийн урилгыг цаг тухай бүр дүүргийн www.chingeltei.gov.mn, цахим хуудагт байршуулж, нээлттэй тендерийн урилгыг хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган өдөр тутмын сонингуудад нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа. Энэ онд өдөр тутмын “Монголын үнэн” сонинд 25, дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудагт 88 тендерийн урилгыг нийтлүүлээд байна. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хүрээнд Чингэлтэй дүүрэгт хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд орж ажиллах захиалагч, иргэн, Төрийн бус байгууллагын төлөөллийг бүрдүүлэх АЗ гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулан иргэний төлөөлөл 21, захиалагчийн төлөөлөл 5, мэргэжлийн байгууллагын төлөөлөл 2, Төрийн бус байгууллагын төлөөлөл 2, нийт 30 хүн хамрагдсан. Сургалтын үр дүнд нийт 9 хүн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ гэрчилгээ авсан болно. Мөн Үнэлгээний хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг ханган тус дүүрэгт 2017 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 34 Үнэлгээний хороодод Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн “Үнэлгээний хороонд иргэдийг оролцуулах тухай” 09 дүгээр тогтоолоор батласан иргэдийн жагсаалтаас 7 иргэн, Төрийн бус байгууллагын төлөөлөл 4 хүн оролцуулсан.</p>	40
21	<p>2.1.5 Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах чиглэлээр шинээр 510 ажил олгогч, 1680 даатгуулагчийг бүртгэснээр шимтгэл тооцох цалингийн сан 1410.0 сая төгрөгөөр нэмэгдэж, нийгмийн даатгалын сангийн орлого 190757.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 196796,6 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөт зорилтоо 103,2 хувиар биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 6039,5 сая төгрөгөөр буюу 3,1%-иар өссөн. Сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан зарласан “Чанартай үйлчилгээ-соёлтой харилцаа” 75 хоногийн аян, Чингэлтэй дүүрэг үүсч байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Нээлттэй өдөрлөг- Нэг цонхны үйлчилгээ” өдөрлөгийг 1-19 дүгээр хороодод 12 удаа, бусад газар хэлтэстэй хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 10 удаа зохион байгуулж, нийт 7450 гаруй иргэн, даатгуулагчид нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжоор мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. Хүнсний биш худалдаа эрхлэгчдэд зориулсан “Хууль сурталчлах сургалт”-д оролцогч 70 худалдаа эрхлэгч, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуйн нэгж байгууллагын 714 инженер техникийн ажилтнууд, “Бөмбөгөр худалдааны төв”, “Нарантуул-2” захын 600 гаруй түрээслэгч нарт нийт 5100 орчим тараах материалыг тараасан. Мөн Ерөнхий боловсролын</p>	40

		<p>сургуулиудын төгсөх ангийн 514 сурагчдын дунд “Даатгалтай ирээдүй” аяныг зохион байгуулж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжуудын ач холбогдлыг сурталчлан ажилласан. Ажил олгогчдод сургалт сургалчиглааны ажлыг зохион байгуулах чиглэлийн хүрээнд 102, 70 дугаар цэцэрлэг, 23 дугаар сургуулийн багш ажилчид, Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, асрагч нар, Нийслэлийн өмчийн харилцааны газрын албан хаагч, “Трансбус” ХХК, “Эс жи эм Ай эм Эм У монголия” ХХК, “Явуу ипмекс” ХХК, “Огоот” ХХК, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Баян айраг эксплорейшн” ХХК, “Оюу толгой” ХХК, “Монголын төмөр зам”, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК, “Тахько” ХХК-ны нийт 714 инженер техник, захиргааны ажилтнуудад нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжуудыг сурталчлах сургалтыг ажлын байранд нь зохион байгуулсан.</p>	
22	<p>2.1.6 Статистикийн тоон мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ.</p>	<p>Дүүргийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн эмхэтгэлийг дүүрэг үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд 1992-2016 оны динамик үзүүлэлтүүдийг багтаахаар ажиллаж, мэдээлэл цуглуулах ажлыг хийж дуусгасан. Дүүргийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар бүр эмхэтгэн нэгтгэж, Нийслэлийн статистикийн газар, дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж байна. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн алдааг тухай бүр хороодод хүргүүлж, орон сууцны төрөл, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг нөхөгдөөгүй мэдээллүүдийн баяжилтыг хийлгэн, алдааг залруулж ажиллаж байна. Үүнд: шилжих тэмдэглэгээ хийсэн 8505, төрөлт 1023, нас баралт 568, хүн амын үзүүлэлтийн 45523 алдааг засуулж баяжилтыг хийлгэсэн. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн алдааг тухай бүр хороодод хүргүүлж, орон сууцны төрөл, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг нөхөгдөөгүй мэдээллүүдийн баяжилтыг хийлгэн, алдааг залруулж ажилласан. ӨС-1 маягтаар орон сууц нөхцөл хангамжийн мэдээг 19 хорооноос авч нэгдсэн судалгааг гаргасан дүүргийн оршин суугчдын аюулгүй байдлын судалгааг цагдаагийн 1,2 дугаар хэлтсийн 2016 оны мэдээнд үндэслэн сүүлийн 4 жилийн тоон үзүүлэлтээр хийж, дүүргийн болон Нийслэлийн статистикийн газрын цахим хуудсанд байршуулсан.</p>	40
23	<p>2.1.7 Монгол Улсын Татварын тухай болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын өр барагдуулалтыг стандартад хүргэж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын бааз суурийг өргөтгөнө.</p>	<p>ТЕГ-ын даргын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн “НӨАТ-ын тухай хууль, НХАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх” А/59 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын А/149 захирамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж төлбөрийн баримт олгох үүрэг бүхий 3922 бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн ажлын байранд очиж НӨАТУС-ийн нэгдсэн цахим төлбөрийн системийн талаар зөвлөгөө өгч ажилласнаар төлбөрийн баримт олгохгүй байгаа 2634 иргэн, аж ахуй нэгжид шаардлага гардуулан хуулийн хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Цахим төлбөрийн баримтын системд 2017 онд шинээр 1322 иргэн, аж ахуй нэгж шинээр бүртгүүлэн холбогдсон байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн 487 ААН, 117 төсөвт болон ТББ нийт 604 ААНБ-ыг татвар төлөгчөөр бүртгэж, 425 хуулийн этгээдийн нэмэлт өөрчлөлтийг хийж, 25 татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөн, 30 татвар татвар төлөгч шилжиж ирснийг журмын дагуу бүртгэж бааз суурийг нэмэгдүүлсэн. 2017 оны 10 сарын 31-ний байдлаар урьд оны нийт 69,990,648.2 мянган төгрөгийн өрийн 28,599,849.1 мянган төгрөг буюу 40.8 хувийг, тайлант онд ногдсон татварын 91,118,377.3 мянган төгрөгийн ногдлоос 74,844,474.8 мянган төгрөгийг буюу 82.1 хувийг барагдуулан төсөвт төвлөрүүлээд байна. Урьд оны болон тайлант оны ногдлын дутуу үлдэгдэлд тухай бүр нь</p>	40

		татвар хураах шат дараалсан процесс арга хэмжээг авч ажилласан.	
2.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ			
24	2.2.1 Дотоодын ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн жилд 2000-аас доошгүй мэргэжилтэй ажилчдыг сургаж, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангана.	Ажил хайж байгаа болон зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллийг өгч холбогдох гарын авлага материалаар хангаж, нийт 1500 иргэнийг ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулснаас ганцаарчилсан зөвлөгөөг 600 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 900 иргэнд өгсөн. Ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирох ажлын байранд холбон зуучлах үйлчилгээг үзүүлснээр 2126 иргэнийг ажил хайгч иргэний бүртгэл Хөдөлмөрийн зах зээл-2 маягтаар бүртгэн авч, холбогдох мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн LMIS-д санд бүртгэлжүүлэн оруулсан. Хөдөлмөрийн зах зээлийн LMIS программын мэдээллийн санд ажил хайгч 2126 иргэн, 147 ажил олгогч, 1500 шинэ ажлын байрыг бүртгэж, ажлын байрны захиалга авч, 1200 иргэнийг байнгын ажлын байранд, түр болон цагийн ажилд 120 иргэнийг зуучилсан. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод хүргэх, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, иргэдийг зөвлөгөө мэдээллээр хангах зорилгоор хороодын Иргэний танхимуудаар дамжуулан 10 гаруй ажлын байрны нээлттэй өдөрлөг болон мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан 2017 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. Мөн иргэдийн хөдөлмөрлөх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор удаан хугацаанд ажил хөдөлмөр эрхлээгүй 1-19 дүгээр хорооны ажил хайгч иргэд, оюутан залуус, шилжин ирэгсэд, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтуудыг явуулж, сургалтад нийт 449 иргэнийг хамруулсан.	40
25	2.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 91 төслийг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн 54 төсөлд 89.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй “Гэгээлэн” /17-р хороо/, “Шинэ хос номин оюу” /9-р хороо/, 16-р хороонд байрладаг “Сайн хөрш” нийгэмлэг, 18-р хороонд байрладаг ХТҮГ-ын харьяа Хүүхэд хамгааллын төвүүдийн үйл ажиллагааг байнга дэмжин тогтмол зардал олгох, хамрагдаж буй хүүхэд багачуудыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдний сурч хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн “Чингэлтэйн боловсрол-2020” хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт суралцах боломжийг бүрдүүлсэн тусгайлан заалт оруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ, Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамруулан сургах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийг 13-19 дүгээр хороонд хэрэгжүүллээ. Мөн дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төвөөр дамжуулан “Гэгээлэн” төвд сурч хөгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй 12 хүүхдэд 7 хоногт 3 удаа 2 цагаар хөгжүүлэх, тэдний эцэг эхчүүдийг гар урлалын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна.	40

26	2.2.3 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний “Чингэлтэй” сүлжээг өргөжүүлэн, залуу ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлнэ.	Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тушаалаар батлагдсан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 57 төсөл, зөвлөх үйлчилгээний 37 төслийг хүлээн авснаас санхүүгийн дэмжлэгт 22 төсөл, зөвлөх үйлчилгээнд 8 төслийг дэмжин 240 цагийн сургалтад ажилгүй, ажил олоход хүндрэлтэй 450 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулсан. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт 19 төсөл хүлээн авч хяналт тавин ажилласан ба ахмад настны эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 38 төсөлд 31.500.000 төгрөг зарцуулсан.	40
27	2.2.4 Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Хамтдаа хөгжье” дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан. Тус хэлтсээс хүлээсэн үүргийн дагуу “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийг дэмжих, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгож ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих заалтын хэрэгжилтийг ханган ажилласан. “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж, “Бүрэн хангалттай”, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн байнгын хорооны хурлаар “Хангалттай”, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж “Бүрэн хангалттай” үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн.	40
2.3 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ			
28	2.3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 23 дугаар тогтоолоор “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, ИТХ-ын “Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо”-ны хуралдаанаар хэлэлцүүлэн “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” үнэлгээ авч, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тайлант хугацаанд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор байгуулагдсан “Чингэлтэйд үйлдвэрлэв” салбар дэлгүүрүүдээр нийт 209 иргэний 1200 гаруй нэр төрлийн 6000 гаруй ширхэг бараа, бүтээгдэхүүн худалдаалагдаж 2017 онд нийтдээ 246,4 сая төгрөгний борлуулалт хийсэн байна. 2016 оны мөн үетэй харьцуулахад борлуулалтын орлого 20.5 сая төгрөгөөр өссөн байна.	40
29	2.3.2 Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Чингэлтэй үйлдвэрлэв хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Бизнес Инкубатор төвөөс Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоног төхөөрөмжийг сайжруулах, өрхийн үйлдвэрлэгчдийг чадавхижуулах зорилгоор төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, тайлант хугацаанд 7-19 хорооны үйлдвэрлэл эрхлэгч 45 иргэнд 103,0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн зөн ОУБ-ын Чингэлтэй болон Хайлааст орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй хамтран эдийн засгийн хөтөлбөрийн хүрээнд 7-18 хороодод өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд тоног төхөөрөмжийн төслийн уралдааныг зохион байгуулж, Чингэлтэйн салбарт 21 иргэн төсөл ирүүлснээс 14 иргэний төсөл дэмжигдэж, 17.7 сая төгрөгний тоног төхөөрөмж, Хайлааст ОННХ салбарт 42 иргэн төсөл ирүүлснээс 18 иргэний төсөл дэмжигдэж 27.8 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг, Чингэлтэй болон Хайлааст орон нутгийн хөгжлийн	40

		хөтөлбөрүүдээс нийт 32 иргэнд 45.5 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлд 6 аж ахуй нэгж, 2 иргэн 1.6 тэрбум төгрөгний зээлд хамрагдаж 48 ажлын байр хадгалагдаж, шинээр 79 ажлын байрыг нэмэгдүүлсэн.	
30	2.3.3 Бизнес инкубатор төвийг бүсчилсэн хэлбэрээр нэмж байгуулна.	Бизнес инкубатор төвийн хөнгөлөлттэй түрээсийн төв байранд 12, 11-р хорооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих салбарт 1, 12-р хорооны салбар байранд 2, 17-р хорооны салбар байранд 2, нийт 17 үйлдвэрлэгч тус тус бойжиж байна. Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөрийн хүрээнд зөөврийн ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэн 2016 онд 30 үйлдвэрлэл эрхлэгчийн ажлын байрыг Миг даатгалтай хамтран гэнэтийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан бол 2017 онд зөөврийн ажлын байрыг 30-аар нэмэгдүүлэх зорилт тавьж, үйлдвэрлэл эрхлэгчийг сонгон шалгаруулж 26 иргэнд шинээр ажлын байр олгосон. 2017 оны байдлаар нийт 56 иргэнийг зөөврийн ажлын байраар ханган шинээр 75 иргэний ажиллах орон тоо нэмэгдсэн.	40
31	2.3.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, оюуны багтаамжтай үйлдвэрлэлийг голлосон инновацийг нэвтрүүлнэ.	Бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, хамтран туршлага судлах зорилгоор Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн ажилтан, 10 гаруй үйлдвэрлэгчдийг хүлээн авч дүүргийн Бизнес инкубатор төв, “Кластерын төв”, “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвүүд, “Чиглэл” ХХК, Зөөврийн ажлын байрны төсөл хөтөлбөрүүдтэй танилцан туршлага судлуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Үйлдвэрлэл Инновацийн газраас хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Дэлхийн Зөн ОУБ-ын Хан-Уул дүүрэг дэх салбарын төсөл хөтөлбөрт хамрагддаг 40 гаруй үйлдвэрлэгчид дүүргийн кластерын төвийн үйл ажиллагаатай танилцан, бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээ, стандартын дэвшилтэт технологи, үйлдвэрлэлийг нэвтрүүлэхэд үйлдвэрлэгчид кластерийн төвийн дэргэд хоршоо хэлбэрээр нэгдэн зах зээлийн судалгаатай, өөрийн бүтээгдэхүүний хаяг, логотой, экспортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нээсэн зэрэг нь бусад дүүргүүдийн хувьд туршлага болохуйц ажил үйлчилгээ болсон байна гэж дүгнэсэн.	40
2.4 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ			
32	2.4.1 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшинг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	Нийслэлийн Засаг даргын орлогчийн баталсан ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын “Үдийн цай” хөтөлбөрт шалгалт хийх удирдамжийн дагуу дүүргийн төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 6, нийт 18 ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд шалгалт хийсэн. Шалгалтанд хамрагдсан сургуулиудад нийт 23904 сурагч, 1174 багш, ажилтан ажиллаж үүнээс 336 бүлэгт 12121 бага ангийн сурагчид “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байгаа нь нийт сурагчдын 48 хувийг эзэлж байгаа буюу 35 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон Ажлын байрны дүгнэлттэй, үлдсэн нь стандартын шаардлага хангахгүй, ажлын байрны дүгнэлтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа тухай дүгнэлтийг Нийслэлийн ажлын хэсэгт хүргүүлсэн. Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Олон улс дахь сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ" ба "Үдийн цай хөтөлбөр"-ийн өнөөгийн байдал сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 18 сургуулийн цайны газрын түрээслэгч, тогооч, сургуулийн эмч, эцэг эхийн зөвлөлийн гишүүн нийт 50 гаруй хүнийг	40

		хамруулсан. МХЕГ-ын даргын 2017 оны “2017-2018 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгах тухай” 01/93 дугаар удирдамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн МХГ-ын даргын баталсан хуваарийн дагуу дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран цэцэрлэгүүдийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил хангагдсан байдалтай танилцаж, хяналт тавьж ажилласан. Шалгалтын үеэр хэсгийн болон зөөврийн усан хангамжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ундны ус нь стандартын шаардлага хангасан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор сорьц авч, НМХГ-ын Нэгдсэн төв лабораторид хүргүүлсэн. Ажлын хэсгээс сургууль, цэцэрлэгүүдэд хичээлийн шинэ жилийг угтаж цэвэрлэгээ үйлчилгээг хийх, мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийлгэх, завсар үйлчилгээг бүрэн хангуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	
33	2.4.2 Худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	“Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 7 худалдааны төвүүдийн захирлуудтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлон АЛБАН ДААЛГАВАР хүргүүлэн ажилласан. Хамтран ажиллах чиглэлийн хүрээнд Нарантуул, Хүчит шонхор төвүүд “Эрүүл хүн-Эрүүл хүнс” аяныг зохион байгуулж нийт 800 гаруй түрээслэгч, 1200 гаруй иргэд хамрагдан хэрэглэгчээ дээдэлсэн соёлтой үйлчилгээ, эрүүл, аюулгүй, баталгаатай бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Аяны хүрээнд Эрүүл мэндийн төвтэй хамтран 7 худалдааны төвүүдийн 2100 гаруй түрээслэгчдээс хүнсний чиглэлээр ажилладаг 810 гаруй түрээслэгчдийг эрүүл мэндийн шинжилгээнд хамруулан Эрүүл ахуйч эмчийн хяналтанд бүртгэлжүүлэх ажил бүрэн хийгдсэн. Тайлант хугацаанд Эрдэнэбулган ХХК 200,2 сая, Анко худалдааны төв нь 6,5 сая төгрөгийн тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэн хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг утсаар, цахим хэлбэрээр хүлээн авдаг ажилтантай болж шинээр 4 ажлын байр нэмэгдүүлэн хэрэглэгч, үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг ханган ажиллаж байна. “Алтжин” худалдааны төвийн урд талбайд “ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулж давхардсан тоогоор 1600 гаруй иргэд, түрээслэгч нарт холбогдох хууль, тогтоомжийг сурталчилж, Алтжин, Содон бөмбөгөр худалдааны төвийн түрээслэгч нарт ажлын байран дах зөвлөгөө өгч мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа. Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргын 2017 оны оны А/835, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/134, дүүргийн Засаг даргын А/97 дугаар захирамжуудын хүрээнд дүүргийн зах, худалдааны төвүүдийн орчимд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээ эрхлэгчид, тос тосолгооны материалын худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд 12 удаагийн хяналт шалгалт хийж, ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэгч 78 иргэнийг хамрууллаа. Хяналт шалгалтын үр дүнд зөвшөөрөлгүй тос тосолгооны 4 цэгийг албадан буулгаж, Бөмбөгөр, Алтжин худалдааны төвийн орчмын 45 иргэний үйл ажиллагааг таслан зогсоож, нийтийн бие засах газар хадгалагдсан 900,0 мянган төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүнийг захиргааны журмаар хураан авч устгасан.	40
34	2.4.3 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцлийг бүрдүүлж, газар тариалан	Тайлант хугацаанд өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжиж, иргэдийг шинэ жимс, хүнсний ногоогоор тогтмол хангах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Адра-Монгол” ОУБ-ын “Өрхийн тогтвортой тариалан төсөл”-д дүүргийн 14, 17, 18, 19 дүгээр хорооны 220 өрхийг хамруулж, 2016 онд 80 өрхөд нэг бүрийн үнэ 460 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 36.8 сая төгрөгийн	40

	<p>эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>хүлэмжийн материалын буцалтгүй тусламж олгогдсон. Мөн АДРА ОУБ-тай хамтран “Өвлийн хүлэмж” сэдвээр сургалт зохион байгуулж 52 иргэнийг хамруулсан. Дүүргийн төсвийн 47,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өвлийн хүлэмж хийх ажлыг бүрэн гүйцэтгэсэн ба өвлийн хүлэмж авах хүсэлтэй, шаардлагад нийцсэн 52 тариаланч иргэдийн судалгааг гарган хүнсний ногоо тариалах талбайн хэмжээг харгалзан иргэдэд олгох ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран “Монгол ногоо” төслийн хүрээнд өрх толгойлсон болон амьжиргааны баталгаажих төвшинээс доогуур орлоготой, өөрийн хашаандаа төмс, хүнсний ногоо тариалах иргэдэд “Хүнсний ногоо тариаланчдад мэдлэг олгох цогц сургалт”-ыг зохион байгуулж, давхардсан тоогоор 83 иргэнийг хамруулсан. Сургалтыг 3 үе шаттай зохион байгуулсан ба сургалтыг танхимын болон үзүүлэх сургалт хэлбэрээр зохион байгуулсан. Иргэдэд эх орны хөрсөнд ургасан, хямд чанартай төмс, хүнсээр хангах ажлын хүрээнд дүүргийн 16 дугаар хороонд хүнсний ногоо худалдаалах чингэлэгт 3, 18 дугаар хорооны Адра ОУБ-ын чингэлэгт 2, 7 дугаар хорооны чингэлэгт 1, нийт 6 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллуулж 6,7 сая төгрөгийн борлуулалт хийгдэж, өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. 1, 14 дүгээр хороонд байрлах Гацуурт ХХК-ны Ногоо худалдаалах чингэлэгт хүнсний ногоо худалдаалж 45.9 сая төгрөгийн борлуулалтыг хийж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн. Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцлийг бүрдүүлж, газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор шинэ ногооны өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг 2 сарын хугацаатай Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 16 тариалан эрхлэгчдийг оролцуулан зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдааны хугацаанд төмс-44 тн, хүнсний ногоо-25 тн, өргөст хэмх-3.5 тн, улаан лооль-4.9 тн, даршилсан ногоо-9500 шил, зөгийн бал 1.6 тн, тарвас 18 тонн борлуулагдаж нийт 150.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн бол Алтжин худалдааны төвийн урд талбайд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд Сэлэнгэ, Төв аймгийн нийт 6 иргэн оролцож 47.8 сая төгрөгийн борлуулалт тус тус хийгдсэн.</p>	
<p>35</p>	<p>2.4.4 Ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санал санаачилгыг дэмжинэ.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээний 26 нэр төрлөөр 535 ААН иргэн үйл ажиллагаа эрхэлдэгээс халуун усны үйл ажиллагаа эрхэлдэг 46 ААН иргэн байна. Үүнээс иргэний өөрийн өмчлөлтэй 38, орон нутгийн өмчид бүртгэлтэй 8 халуун усны газар дүүргийн гэр хорооллын 127593 иргэнд халуун усны үйлчилгээг үзүүлж байна. 2017 онд иргэдийн өөрийн хөрөнгөөр шинээр 5 халуун усны газар ашиглалтад орсныг бүртгэж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, “Халуун ус-MNS 5164:2010 стандарт”-ыг мөрдүүлэн ажиллаж байна. Мөн 4 дүгээр хороонд байрлалтай “Огших тэргэл” ХХК-ны Дрийм саун, Бөхбат ХХК-ны Маргад сауны газрууд нь Стандартчилал, хэмжил зүйн газраас олгодог “Тохирлын үнэлгээ”-нд хамрагдаж гэрчилгээ авсан. Дүүргийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 10 дугаар хороонд баригдсан “Ахуйн үйлчилгээний бичил төв”-ийн ажлын байранд хувцас засвар, оёдол, эсгүүр, үсчин, бичиг хэрэг, канон, цахилгаан барааны засварын чиглэлээр үйлчилгээ үзүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг 3 удаагийн уулзалтаар шийдвэрлэн, 9 ажлын байрыг 7 иргэнд хүлээлгэн өгч, цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. “Гүүд нейборс” ОУБ-ын хөрөнгө оруулалтаар дүүргийн 19-р хороонд “Халуун ус, ахуйн үйлчилгээний төв” байгуулахаар Засаг даргын 2016 оны А/771 дүгээр захирамжаар газрын асуудал шийдвэрлэгдсэн боловч халуун усны үйлчилгээ</p>	<p>40</p>

		нь зардал ихтэй, хөрсний бохирдол үүсгэдэг гэсэн шалтгаанаар санхүүжүүлэгч байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх хүсэлт гаргасны дагуу Иргэдийн бизнес хөгжлийн төв болгохоор шийдвэрлэн, засвар тохижилтын ажил хийгдэж байна.	
ГУРАВ: ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ			
3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА			
36	3.1.1 Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр тодотгон хэрэгжүүлнэ.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан дүүргийн 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Бүрэн хангалттай” гэж дүгнэсэн. 2017 онд нийслэлийн төсөвт 400,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 336,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 2017 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 84,1% -тай байна. Иргэд, аж ахуйн нэгжээс газар эзэмших эрх шийдвэрлэх хүсэлт ирүүлсэний дагуу 2017 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар дүүргийн Засаг даргын 85 удаагийн захирамжаар 1607 иргэн аж ахуй нэгжийн 96,4 га газрын эрх зүйн харилцааг шийдвэрлэсэн. Үүнээс иргэний ахуйн зориулалтаар 1551 иргэн аж ахуй нэгжид 93 га, аж ахуйн зориулалтаар 56 иргэн аж ахуйн нэгжид 6,4 га газрыг тус тус захирамж шийдвэр гаргаж, Газрын харилцаа Геодези Зураг зүйн газрын даргын 2008 оны 83 тоот тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” -ын дагуу газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгоод байна.	40
37	3.1.2 Иргэдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх болон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой мэдээллийг нээлттэй ил тод болгоно.	Газар өмчлөлийн LPIS.2.0 программ хангамжийг боловсронгуй болгож, газар өмчлөгчийн өгөгдлийн мэдээллийн баазыг өргөтгөж ажиллалаа. Тус мэдээллийн баазад гэр хорооллын нийт иргэдийн 78 хувь буюу 17800 иргэн нь газраа өмчилж авсан бүртгэлтэй байна. www.utmс.ub.gov.mn сайтанд цахимаар газар өмчлөх талаар мэдээллийг дэлгэрэнгүй байршуулсан ба хороодын нэг цонхны үйлчилгээгээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 11 удаагийн захирамжаар 338 иргэнд 16.2 га газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлсэн. Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяны хүрээнд дүүргийн 7-13 дугаар хорооны газар өмчлөөгүй айлын судалгааг гарган материалын бүрдлийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 101, 187 дугаар тогтоолоор батлагдсан хаягжилт, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу зуслангийн амуудад газар эзэмшиж буй иргэдэд газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 11 удаагийн захирамжаар 338 иргэнд 16,2 га газрыг нэг удаа үнэгүйгээр өмчлүүлсэн. Үүнээс хашааны газраа өмчилсөн 171, зусланд газраа өмчилсөн 167 иргэн байна. Хамтран өмчлөгчөө хасуулах болон Кадастрын зурагт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан 123 нэгж талбарт хамаарах 298 иргэний материалыг “Газар өмчлөлийн шийдвэрийн төслийг бэлтгэх” ажлын хэсгийн хуралдаанд танилцуулан нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Эдгээр иргэд цахимаар болон орон нутагтаа газар өмчилж авах эрх нь нээлттэй болсон.	40
38	3.1.3 Дүүргийн нутаг дэвсгэрт тохилог орон сууц, амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэгчдийг дэмжин ажиллаж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд	Дүүргийн 19-р хороо салхитын аманд газар дахин шинэчилэн сайжруулах тохилог, инженерийн дэд бүтэцтэй амины орон сууцны хороолол бий болгох үүднээс “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт тусгасны дагуу газар шинэчлэн зохион байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг, инженерийн дэд бүтцийн хангамжийн ажлын зураг	40

	<p>холбогдсон тохилог сууцнуудыг бий болгоно.</p>	<p>төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Мөн төслийн хүрээнд Тусгаар тогтнолын талбайд “Изо Хаус” ХХК-тай хамтран Канад модон хийцтэй угсармал зөөврийн амины орон сууцны танилцуулгыг гаргаж 2016 онд 3000 гаруй иргэн, 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 3500-д иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч байна. Мөн Барилга хот байгуулалтын яам, Нийслэл, Дүүргийн зүгээс хэсэгчилсэн инженерийн хангамж бүхий Дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийг барьж байгуулах ажлын хүрээнд дүүргийн гэр хорооллын иргэдэд “Сервис центр”-ийн талаар танилцуулах, мэдээлэл өгөх уулзалтыг дүүргийн 7-19 дүгээр хороодын 800 орчим иргэнийг хамруулж, мэдээлэл өгч ажилласан. Дээрх сургалт, уулзалтын хүрээнд 7, 17, 19 дүгээр хороонд хэд хэдэн “Иргэдийн бүлэг”-ийг иргэд өөрсдөө зохион байгуулж, Дэд бүтцийн төв барих ажлыг дэмжиж байгаа талаар хүсэлтээ албан ёсоор ирүүлсний дагуу иргэдийн хүсэлтийг хүлээн авч, Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газарт уламжлан хүргүүлсэн. Одоогийн байдлаар 7, 14, 16, 17, 18, 19 дүгээр хороодод 10 орчим иргэдийн бүлэг байгуулагдаж, 7 дугаар хорооны 1 байршилд төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэж, Нийслэлийн 2018 оны төсөвт хөрөнгө нь суугдаад байна.</p>	
39	<p>3.1.4 Олон жил болсон орон сууцны байрнуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.</p>	<p>Нийслэлийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4-р хорооны 54-р байрны дээврийн засварын ажлыг 58,2 сая төгрөгөөр “Дэл” ХХК, 5 дугаар хорооны 17 дугаар байрны дээврийн засварын ажлыг “Болор эм би” ХХК 43,9 сая төгрөгөөр, 6-р хорооны 62/1, 53 дугаар байруудын дээврийн засварын ажлыг “ЭЭБТ” ХХК 54,4 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 6-р хорооны 45-р байрны фасад засварын ажлыг “Төгс үлэмж чанар” ХХК гүйцэтгэж байна. Мөн дүүргийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хорооны ТЕГ-50 дугаар байрны фасад засварын ажлыг “Энэрэлт их эрдэнэ” ХХК 49,8 сая төгрөгөөр, 2-р хорооны 23-р байрны дээвэр засварын ажлыг “Хоовжий” ХХК 68,8 сая төгрөгөөр, 3-р хорооны 40-0-тын 13 дугаар байрны фасад засварын ажлыг “Их галдайн оргил” ХХК 48,9 сая төгрөгөөр, 4-р хорооны 39-р байрны фасад засварын ажлыг Зэндмэнэ тулга ХХК 49,9 сая төгрөгөөр, 5-р хорооны 12 дугаар байрны фасад засварын ажлыг “Мөнхтэнцвэрт өргөө” ХХК 49,9 сая төгрөгөөр, 6-р хорооны 58 дугаар байрны дээвэр засварын ажлыг “Тэгш өргөө” ХХК 45,8 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар нийт 5 байрны фасад, 6 байрны дээврийн засварын ажил хийгдсэн.</p>	40
40	<p>3.1.5 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг шинээр нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага-хяналтын системд холбоно.</p>	<p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “И Пи Эс” ХХК 7, 8, 10, 12 дугаар хороонд, “Согриглүн” ХХК 15, 17, 19 дүгээр хороонд, “Филипс гэрэлтүүлэг” ХХК 13, 14, 16 дугаар хороонд тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 133 ширхэг гэрэлтүүлэг 218,3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэж буй авто зам дагуух гэрэлтүүлгийг “Соёндрийм” ХХК шинээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 11, 12 дугаар хороо, Самбалхүндэвийн эргэмжийн газраас Дэнжийн мянган авто замтай нийлэх авто зам дагуу 19 гэрэлтүүлэг, 7, 10 дугаар хорооны авто зам дагуу 33 гэрэлтүүлэг, 11 дүгээр хорооны байрлуу явсан авто зам дагуу 15 гэрэлтүүлэг, 17 дугаар хорооны байрлуу явсан авто зам дагуу 7 гэрэлтүүлэг, 19 дүгээр хорооны байрлуу явсан авто зам дагуу 8 гэрэлтүүлэг, Гахайн байрнаас Баянхошууны хөтөл хүртэлх 0,9 км зам дагуу “Билэгт зам” ХХК 27 гэрэлтүүлэг нийт 109 ширхэг гэрэлтүүлгийг 155,3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь “Их цамхаг хүрээ” ХХК-тай хамтын ажиллагааны</p>	70

		<p>гэрээ байгуулсан бөгөөд 4 дүгээр хороо Самбуугийн гудамжинд 24 ширхэг, 12-р хорооны өрхийн эмнэлэгийн гадна 4 ширхэг, 17-р хорооны Баянхайрхан 4-р гудамжинд 26 ширхэг эрчим хүчний хэмнэлттэй, орчин үеийн дэвшилтэт техникийн бүхий нарны зайн эко гэрэлтүүлэг нийт 54 ширхэгийг дүүргийн төсвийн хөрөнгөөр хийсэн. Мөн 4-15 дугаар хороодод 200 ширхэг гэрэлтүүлэг нөхөн суурьлуулалт хийгдсэн ба нийт дүүргийн хэмжээнд 496 гэрэлтүүлэг хийгдээд байна.</p>	
3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ			
41	<p>3.2.1 Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, асфальт, бетонон болон байгалийн чулуун замуудаар гэр хорооллын гол гудамжуудыг төв замтай холбож, олон чиглэлийн зам харилцааг хөгжүүлнэ.</p>	<p>Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр 2 дугаар хороо, Бэтүб хийдийн зүүн талаар Самбуугийн гудамжтай холбогдох 110у/м байгалийн чулуун замыг “Хайдро проект” ХХК 73,2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Мөн 5 дугаар хороо, Чандмань төвийн баруун талаас 2А байрны авто замтай холбох 75 у/м авто замын ажлыг 45,2 сая төгрөгөөр нийт 118,4 сая төгрөгөөр байгалийн чулуун замын ажил хийж гүйцэтгэсэн. Мөн нийслэлийн хөрөнгөөр авто замын нөхөөс 1-6 дугаар хороонд 1000м2 талбайд 50,0 сая төгрөгөөр Улаанбаатар Зам, засвар арчлалтын газар хийж гүйцэтгэсэн. Дүүргийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар хорооны Жуулчны гудамж “Урт цагаан”-ы үйлчилгээний төвийн өмнө 3158 м2 талбайн авто зогсоолыг шинэчлэх ажил хийгдэж, 130 авто машин зогсох хүчин чадалтай даацын эко хавтан, явган хавтан бүхий 4 ширхэг орц гарцтай авто зогсоолын гүйцэтгэгчээр дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК ажилласан. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдсэн 4 дүгээр хороо “Хийморь” цогцолбор байрны зүүн талын тохижилтын ажилтай уялдуулан “МАКС ГРУПП” ХХК авто замыг өргөсгөх, бордюр шинээр солих, замын хөдөлгөөн тусгаарлах зурвас хийж иргэдийн чөлөөтэй зорчих ая тухтай байдлыг ханган ажилласан. Нийслэлийн хөрөнгөөр 2016 оны концессийн гэрээгээр хийгдэж эхэлсэн ажлын үргэлжлэл 16 хороо Баянхошууны хөтөл “Ринг роуд” ХХК, 19 дүгээр хороо Яргайтын богино “ХАКМС” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн 2017 оны хөрөнгөөр 12, 16 дугаар хороо Дэнжийн мянгын авто замын үргэлжлэл 0,9 км замыг “Билэгт зам” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 11, 12 дугаар хороо, Самбалхүндэвийн эргэмжийн газраас Дэнжийн мянгын авто замтай нийлэх 0,52 км авто замын ажил хийгдсэн бөгөөд 7,10 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хувьсгалчдын замаас Дэнжийн мянгын цагаан байрны хойд талын зам буюу “Ундром” дэлгүүрийн авто замтай нийлэх 1,2 км авто замын ажил хийгдсэн. Мөн 9, 11, 13, 17, 18, 19 дүгээр хорооны байр луу нийт 1,1 км авто замын ажил хийсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7 дугаар хороо, Эрх зүйн туслалцааны төвөөс Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх 0,39 км авто зам, Зурагтын шинэ эцсээс Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх 0,34 км авто зам нийт 0,73км замын ажлыг “Өргөн говь” ХХК хийж гүйцэтгэсэн. 17 дугаар хороонд орц гарцыг сайжруулах ажлын хүрээнд Сургуулийн 58-59, 31-35, 81 дүгээр гудамжуудад нийт 3 байршилд 130 у/м байгалийн чулуун зам хийгдээд байна. Дүүргийн хэмжээнд нийт 16 байршилд 9.1км авто зам 6,4 тэрбум төгрөгөөр хийгдсэн.</p>	40
42	<p>3.2.2 Сэлбэ дэд төвийн төслийг үргэлжлүүлэн хийж дуусгахад хамтран ажиллана.</p>	<p>Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хамтарсан 1 тэрбум төгрөгний санхүүжилтээр хэрэгжиж байгаа Дүүргийн нутаг дэвсгэрт Гэр хорооллын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд "Сэлбэ дэд төв" 2.2 км урттай, DN400 мм-ийн DI бохир усны коллектор шугамын барилгын ажил 7 буудлаас Хайлаастын замын уулзвар хүртэл 14, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт төв замын баруун талаар хийгдэж дууссан.</p>	40

		Сэлбэ дэд төвийн хүрээнд СБД-ийн 13, 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14, 15, 18, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр болох 158 га талбайд 26.68 МВТ хүчин чадал бүхий дулааны станц болон инженерийн шугамын ажил хийгдсэнээр 6 мянга орчим өрхийн 25400 хүн төвлөрсөн дулаан хангамж бүхий сууцанд амьдрах боломж бүрдэх юм. Мөн 240 хүүхдийн ортой цэцэрлэг, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Бизнес инкубатор төв зэрэг нийгмийн байгууламжийг барихаар төлөвлөн холбогдох байгууллагуудтай хамтран газар чөлөөлөлтийн ажлыг хийж байна.	
43	3.2.3 Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй бүх өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хийнэ.	Дүүргийн хэмжээнд 2017 онд гэр хорооллын 11 хорооны нутаг дэвсгэрийг хамарсан 1496 өрх хүчдэлийн уналттай хэсгийн судалгаанд хамрагдсан бөгөөд Улсын төсвийн хөрөнгөөр 5 хорооны 369 өрх, дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 хорооны 181 өрх хүчдэл сайжруулах ажилд хамрагдсан. 2017 онд дүүргийн хэмжээнд цахилгаан эрчим хүчнийг сайжруулах, шинээр эрчим хүчинд холбосон 935 өрх буюу 78.5 хувийн хүчдэл сайжраад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Би Эн Жи Эл” ХХК 19-р хороо АТП827 дэд өртөөний өргөтгөл, 18-р хороо Яргайтын гудамж АТП, 7-р хороо КТПн ачаалал хөнгөлөх ажил 69 өрх, “Дархан Ферагон” ХХК 16-р хороо Согоотын 83-р гудамж 51 өрх, 17-р хороо Сурагчийн 6, 7-р гудамж, Зүрх уулын орчим 42 өрх, Тахилтын 3 гудамж 42 өрх “Хүрд” ХХК, 16-р хороо Согоотын 2-р гудамж 87 өрх, 19-р хороо Өвөр гүнтийн орчим 78 өрх цахилгаан сайжруулах ажлууд хийгдсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 18 дугаар хорооны 21 өрхийг хамарсан зарим байршилд “Сүлжээний урсгал” ХХК 25,7 сая төгрөгийн санхүүжилтээр 21 тоолуур бүхий 12 тулгуур, 700 метр шугамын ажил гүйцэтгэж дууссан. 16-р хороо Согоотын 90, 86-р гудамжны айл өрхөд цахилгааны шугам татах /45 өрх/ ажил, 19-р хороо Ар согоотын гудамжны айл өрхөд цахилгааны шугам татах /70 өрх/ ажил, 16-р хороо Согоотын 59а гудамжны 45 өрхөд шинээр цахилгаан эрчим хүчээр хангах 165Ква -н КТПН дэд станц 0,4Ква агаарын шугамын ажлууд тус тус хийгдсэн.	40
44	3.2.4 Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган шат, гүүр, ус түгээх байр барьж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	Дүүргийн иргэдийн бүлгийн оролцоотой хийгдэх явган зам, тохижилтын ажил болох 4, 5, 7, 8, 9, 18 дугаар хороонд нийт 7 байршилд ажлын зураг, тоо хэмжээ гарган батлуулсаны дагуу 18 дугаар хороонд “Хүчилтөрөгч” иргэдийн бүлэг 700 ширхэг том, 111 ширхэг жижиг, 8 дугаар хороо, Найрамдал иргэдийн бүлэг 39 ширхэг том, 850 ширхэг жижиг, 7 дугаар хороо, Эв нэгдэл иргэдийн бүлэг 113 ширхэг том, 1520 ширхэг жижиг, нийт 852 ширхэг том, 2481 ширхэг жижиг гудамжны хаяг, 18-р хороо, Яргайтын 19, 22 дугаар гудамжны заагт явган хүний зам тавих, 15-р хороо, 84-ийн автобусны буудлаас Чингэлтэй өгсдөг авто гүүрэнд хашлага хийж тохижуулах, 4 хороо, 18-р байрны урд явган хүний зам тавих, 5 хороо, 7-р байрны урд талд явган хүний зам тавих, 5 хороо, 15-р байрны урд талд явган хүний зам тавих, 6 хороо, 41, 43, 45-р байрны орчмын явган хүний замыг шинэчлэх, 9-р хороо, Цагаан байрны автобусны буудал орчмын тохижилт хийсэн. Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдлыг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт 7 хорооны 12 байршилд дүүргийн төсвийн хөрөнгөөр зөөврийн ус түгээх байр 1 ширхэг, шугамын ус түгээх байр 1 ширхэг, гүний худаг 8 ширхэг, Нийслэлийн хөрөнгөөр зөөврийн ус түгээх байр 2 ширхэг нийт 3000 орчим өрхөд хүртээмжтэй ус түгээх байр баригдсан. Үүнд: 19 дүгээр хороо, Доод салхитад 1 ширхэг зөөврийн ус түгээх байр, 17 дугаар хороо Олон булагтай цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд 1 ширхэг шугамын ус түгээх байр, 18 дугаар хороо яргайтын 83-р гудамжинд 1 ширхэг гүний худаг, 17 дугаар хороо Зүрх	40

		уулын 3 дугаар гудамжинд 1 ширхэг, Баян хайрханы 7 дугаар гудамж, Сурагчийн 49 дүгээр гудамж гүний худаг, 16 дугаар хороо Согоотын 90-р гудамжинд 1 ширхэг гүний худаг гүйцэтгэгч “Шинь хөн” ХХК гүйцэтгэв. Мөн 13, 14, 15 дугаар хорооны зааг, 12 дугаар хороо Булгийн 15 дугаар гудамжинд тус тус гүний худаг баригдсан. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар хороо, Хувьсгалчдын “В” 13 дугаар гудамж 1 ширхэг, 12-р хороо Булгийн 19-р гудамжинд 1 ширхэг Зөөврийн ус түгээх байр барьж гүйцэтгэсэн.	
45	3.2.5 Иргэдийн эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн шинэ чиглэл бий болгох ажлыг дэмжин хамтран ажиллана.	Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд дүүргийн зүгээс 7 дугаар хороо, Хувьсгалчдын гудамж Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэл хотын төв рүү орох Баянгол дүүрэг талдаа шинээр автобусны дундын зогсоол нэмэх, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 гудамж Хүчит шонхор захын зүүн талын автобусны дундын зогсоолын хэмжээ нэмэх тусгаарлах хашлага хийх, 13 дугаар хороо, Чингэлтэйн өргөн чөлөө 56 дугаар цэцэрлэгийн автобусны дундын зогсоолыг шилжүүлэх, 14 дүгээр хороо, Чингэлтэйн өргөн чөлөө 6 буудлын автобусны дундын зогсоолыг шилжүүлэх 4 байршилд санал гарган хүргүүлсэн. Тээврийн газарт дүүргийн хэмжээнд төв замаас алслагдсан нийтийн тээврийн чиглэлийн хүртээмж муу талаар 7, 10 дугаар хороодын иргэдээс ирсэн санал хүсэлтийн дагуу тус хороодын нутаг дэвсгэрийг хамарсан “Алтан дорнын хүч” ХХК-ны боловсруулсан нийтийн тээврийн чиглэл нэмэгдүүлэх төслийг хүргүүлэн ажилласан. Мөн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд дүүргийн иргэдийн бүлгийн оролцоотой хийгдэх ажлын хүрээнд 9-р хорооны автобусны буудлын тохижилтын ажлыг Дэнж иргэдийн бүлэг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 18 дугаар хороо Сургуулийн буудлаас- хотын төвийн чиглэлд дүүргийн хөрөнгө оруулалтаар "АВТОБУСНЫ БУУДЛЫН САРАВЧ" барьж ашиглалтанд оруулав. Зуны хуваарь 6 дугаар сарын 10-наас шөнийн тээврийн ШҮ:1 "5 шар-Ботаник", ШҮ:2 "Нисэх-МУБИС-Ард", ШҮ:3 "Зунжин-7 буудал-МУБИС" чиглэлд нийтийн тээврийн автобус үйлчилнэ. Тус чиглэлд 22:30 цагаас 01:30 цаг хүртэл явж байна. Мөн зуслангийн чиглэлийн зорчих эрэлтэд үндэслэн ЗҮ:1 "Гүнт-Жигжид-Тэнгис кино театр" чиглэлд 3 тээврийн хэрэгсэл, ЗҮ:2 "Гоодой-Тэнгис кино театр" чиглэлд 1 тээврийн хэрэгсэл, ЗҮ:3 "Баянбулаг-Тэнгис кино театр" чиглэлд 1 тээврийн хэрэгсэл тус тус үйлчилгээнд гаргасан.	40
ДӨРӨВ: ЖАРГАЛТАЙ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ			
4.1 БАЙГАЛЬ ОРЧИН			
46	4.1.1 Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны тогтоолоор дүүргийн “Ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрсний тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг хатуу хучилттай болгох ажлын хүрээнд 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10,11, 12, 13, 16, 17, 18, 19 дүгээр хороо нийт 15 хороодод нийслэл, дүүргийн хөрөнгөөр 2930 м2 эко хавтан, 1619,8м2 бетонон зам, 5953,5м2 байгалийн чулуу, 46749 м2 асфальтан хучилт, 20795,5 м2 явган зам нийт 78047,8 м2 талбайд хатуу хучилт хийж гүйцэтгээд байна. Нийтийн эзэмшлийн талбайд 3390 м2, орон сууцны хороолол дундах бичил цэцэрлэгүүдэд 2060 м2, цэцэрлэгүүдэд 5162 м2, нийт 10612 м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн. Нийтийн эзэмшлийн талбайд 509 м2, орон сууцны хорооллын дунд бичил цэцэрлэгүүдэд 27 м2, цэцэрлэгүүдэд 1634 м2 нийт 2170 м2 талбайд цэцгийн мандал байгуулсан. Дүүргийн хэмжээнд 2017 онд нийт мод 7267 ш, амьд хашлага 6893 ш, бут сөөг 5597 ш таригдаж, нийт 10612 м2 талбайд зүлэгжүүлэлт	70

		хийгдсэн. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламжийн арчилгааны ажлын хүрээнд Анкарагийн гудамж, Бага тойруугийн, Явуухулан цэцэрлэг хүрээлэн, Самбуугийн гудамж, Учралын цэцэрлэг, Лааганы гудамж, Дүүргийн өндөрлөг зэрэг 7 байршилд Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-ийн 22 хүний бүрэлдэхүүнтэйгээр ногоон байгууламжийн арчилгааны ажил хуваарийн дагуу хийгдсэн. Дүүргийн хэмжээнд хөгширсөн ургалтгүй 32 ширхэг мод байгаагаас Анкарагийн гудамжны хөгширсөн ургалтгүй 12 ширхэг модыг чөлөөлж, Ататуркийн нэрэмжит 5 дугаар сургуулийн урд талын ургалтгүй хөгширсөн 3 ширхэг модон дээр “Тохижилт үйлчилгээ” ХХК-тай хамтран сийлбэр хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Чингэлтэй дүүргийн иргэдэд мод тарихад уриалж, тэднийг дэмжих ажлыг БОАЖЯ-наас санаачлан, “Ногоон дүүрэг” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5, 10-р саруудад 2 удаагийн сургалт явуулж 1-19 дүгээр хорооны 156 иргэдийг хамруулан “Ногоон байгууламжид таригдсан мод сөөгний усалгаа, арчилгаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтын үеэр 3 төрлийн 270 гаруй мод, суулгац иргэдэд тарааж өгсөн. Иргэд, олон нийтэд байгаль орчны талаарх мэдлэгийг түгээн, таниулан сурталчлах, иргэдийн санал санаачлагыг дэмжин ажиллах, түүнчлэн хотын иргэний соёлыг төлөвшүүлэх, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор “Чингэлтэй дүүрэг орчмын байгалийн ургамлыг нөхөн сэргээх арга өнгөт зургийн цомог” бүтээх ажлыг зохион байгуулж, нийт 500 ширхэг ном хэвлүүлэн ерөнхий боловсролын 24 сургуульд 300 ширхэг номыг сургалтын хэрэгцээнд ашиглуулахаар хүлээлгэн өгсөн.	
47	4.1.2 Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоныг байгуулна.	Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/706 тоот захирамжаар дүүргийн 17 дугаар хороонд Чингэлтэй хайрхан явган аялалын чиглэлийг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийг тохижуулах ажлыг “Сагсай Өргөө” ХХК гүйцэтгэсэн бөгөөд тус ажлын хүрээнд 3 ширхэг амрах цэг, 10 ширхэг сандал хийж, мэдээллийн самбар зүг заасан тэмдэглэгээ байршуулах ажлууд хийгдсэн. Дүүргийн 17, 18, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Чингэлтэй хайрхан уулын орчмын улсын тусгай хамгаалалтын цэг тэмдэглэгээ хийх ажил”-ыг нийт 58 км урт, 1000 ш 1.5 м өндөртэй бетон шон суулгаж, цэг тэмдэгжүүлэх ажлыг “Мөрөөдлийн зөв зам” иргэдийн бүлэг болон “Бүтээлч үйлс” иргэдийн бүлэг хийж гүйцэтгэсэн. Чингэлтэй хайрхан уул орчмын улсын тусгай хамгаалалтын хашаажуулалтын ажлын хүрээнд “Бодь хангай” ХХК нь нийт 600 ширхэг буюу 1252 м хашааг шинээр барих, хуучин 335 ширхэг буюу 670 м хашааг буулгаж шилжүүлэх ажлыг он дамжин хийж гүйцэтгэж байна. Чингэлтэй хайрхан Дээд салхит уулын аманд “Эрдмийн цэцэрлэгт” хүрээлэн бүхий амралт, аялал зугаалгын бүс болгон тохижуулахаар 230 у/м байгалийн чулуун авто зам, 460 м ² явган зам, Самбуугийн гудамжинд хэрэглэгдэж байсан 47 ширхэг гэрэлтүүлэг, усалгааны систем суурьлуулж ажилласан. Тус цэцэрлэгт хүрээлэнд байгуулагдах задгай талбайн 1-р ээлжийн ажлын хүрээнд 13 эгнээ байгалийн чулуун сандал суурьлуулах ажлыг хийж дууссан. Мөн “Эко тогтол” ХХК спорт цогцолборын ажлыг хийж гүйцэтгэж байна.	40
48	4.1.3 Ногоон байгууламж, тохижилт бүхий “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулна.	Чингэлтэй хайрхан Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд 197 ширхэг шилмүүст мод шилжүүлэн суулгаж, 600 ширхэг шинэс, 108 ширхэг нарс мод, 78 ширхэг гацуур мод, 96 ширхэг бургас, 125 ширхэг улиас мод, 50 ширхэг монос мод, 408 ширхэг хус мод, 100 ширхэг гүйлс нийт 1762 ширхэг мод тарилт хийгдсэн.	40
4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ			
49	4.2.1 Хог хаягдлын менежментийг	Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлын чиглэлээр “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд”	40

	<p>сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	<p>ХХК байгууллагууд төвийн хороо болон гэр хорооллын айл, өрх аж ахуйн нэгжүүдийн хог тээвэрлэлтийн хуваарь гарган дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хуваарийн дагуу тогтмол тээвэрлэлт явуулж байна. Хог хаягдлын менежментийг сайжруулах, тээвэрлэх ажлын хүрээнд хороо тус бүрд хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын тохижилт, цэвэрлэгээний үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн 1-19 дүгээр хорооны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлыг цуглуулж тээвэрлэхэд “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК 40 орчим техник, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр ханган тогтмол ачиж тээвэрлэн 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 23300 гаруй рейсээр 140000 гаруй тонн хог хаягдлыг устгалд оруулан төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллаад байна. Мөн Нийслэлийн 378 жилийн ойн хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/63 тушаалын дагуу нийслэлийн зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийг гүйцэтгэдэг байгууллага аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажлын шинэ арга барил бүхий санал санаачлагыг дэмжих зорилгоор зохион байгуулсан “Хоггүй гудамж, хоггүй хороо” болзолт уралдаанд “Чингэлтэй дүүргийн Тохижилт, үйлчилгээ ХХК” манлайлан тэргүүн байрыг эзэлсэн ба ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан “Чингэлтэй дүүргийн Тохижилт, үйлчилгээ” ХХК-ийн зам тээврийн үйлчлэгч, жолооч болон “Найши трейд” ХХК-ийн жолооч нар Тайланд улсад аялах эрхийн бичгээр шагнуулсан.</p>	
<p>50</p>	<p>4.2.2 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт сэргээгдэх эрчим хүч болох нарны зайн гэрэлтүүлгийг 4 дүгээр хороо, Самбуугийн гудамжинд 24 ширхэг, 12-р хорооны өрхийн эмнэлэгийн гадна 4 ширхэг, 17-р хорооны Баяхайрхан 4-р гудамжинд 26 ширхэг, нийт 54 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулсан. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газар, Эрчим хүчний яамнаас хэрэгжүүлж буй цахилгааны хөнгөлөлтөд 19579 өрх хамрагдсан. НЗДТГ-аас хэрэгжүүлж буй ХЕПА шүүлтүүртэй агаар цэвэршүүлэгч төхөөрөмж /80 м2 тасалгааны агаар дахь нян, бактери, хөгцийг 60-80%-аар устгаж утаа, тоос тоосонцор, бохирдлыг шүүж цэвэрлэдэг бөгөөд эрчим хүчний зарцуулалт багатай, шөнийн ухаалаг горимоор ажиллах хүчин чадалтай/-ийг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад 16 ширхэг /17, 39, 57 дугаар сургуулиуд/, цэцэрлэгүүдэд 8 ширхэг /31, 56, 83, 102, 103, 124, 126, 154/, дүүргийн Эрүүл мэндийн төвд-24 ширхэг, нийт 48 ширхэг хүлээлгэн өгч суурилуулаад байна.</p> <p>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Гүүд шейринг ХХК-тай дулаан баригч, Монгол базальт ХК-тай дулаалга, Мон ватт ХХК-тай халаах төхөөрөмж, Дашваанжил ХХК-тай Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдал багасгах ажлын хүрээнд Гүүд шейринг ХХК-тай хамтран 1531 айл өрхийн зууханд дулаан баригч суурьлуулсан. Айл өрхийн хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Даншваанжил ХХК-тай хамтран 300 гаруй өрхөд сургалт зохион байгуулсан. Утааг багасгах ажлын хүрээнд айл өрхүүдэд Мон ватт ХХК-тай хамтран Эко тулгат зуух буюу халаах төхөөрөмжийг сурталчилан ажиллаж байна. Гэр хорооллын айл өрхийн дулаан алдагдлыг бууруулах дулаалгын аяныг гэр хорооллын 13 хороонд өрнүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд гэр хорооллын 13 хорооны 1400 гаруй иргэдэд сургалт зохион байгуулж, 39 айл өрхийн байшинд дулаан алдагдлын талаар хэмжилт хийж газар дээр нь зөвөлгөөг өгч, дулаалах 13 өрхийг сонгон дулаалах ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийт 6 төрлийн сургалтыг үе шаттай зохион</p>	<p>40</p>

байгуулан ажиллаж байна.

ТАВ: ЖАРГАЛТАЙ ИРГЭН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ

5.1 НУТГИЙН УДИРДЛАГА

51	5.1.1 Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага тооцох системийг оновчтой хэрэгжүүлж, тэдний ажиллах таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор дүүргийн “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүний нөөцийн хөгжил нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх 7 бүлэг 34 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор “Мэдээллийн цаг сургалт”- ыг 12 удаа зохион байгуулсан. Хороодын ажилтан, албан хаагч, хэсгийн ахлагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар холбогдох сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран үе 26 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 745 төрийн албан хаагч, хамрагдсан. Шинэ ажилтны сургалт зохион байгуулж Засаг даргын Тамгын газар, хороодын нийт 16 шинээр томилогдсон албан хаагчид оролцлоо. Гадаадын улс оронд ажлын туршлага судлуулах, сургалтад хамрагдах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНТУ-н Анкара, Истанбул, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур, БНСУ-ын Ёнсу дүүргүүдтэй хамтын ажиллагааны хүрээнд холбогдох чиглэлээр санал солилцох, туршлага судлах арга хэмжээнд 12 албан хаагчдыг хамруулсан. Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, өвчлөлтийг эрт илрүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг “Сөүл сонгдо” эмнэлэгтэй хамтран нийт 166 ажилтан, албан хаагчдыг үзлэгт хамруулсан. Засаг даргын Тамгын газар, хорооны 6 төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгуулж, 12 албан хаагчдад зэрэг дэвийн шатлал ахиулсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон, Тамгын газар, хороод, дэргэдэх хэлтэс албадын 15 албан хаагчдыг тангараг өргүүлсэн. Мэргэжлийн Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу Тангарагийг 3 нягтлан бодогч өргөсөн. 2017 оны ажлын хэрэгжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар орж “Бүрэн хангалттай” дүгнэгдсэн.	40
52	5.1.2 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газраас олон нийтийн хэвлэл мэдээллийн TV5, UBS, STAR, MN25 телевизүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар телевизээр нийт 120 мэдээ мэдээлэл, цахим мэдээллийн сайтуудаар 157 мэдээ мэдээллийг гарган ажилласан. Мөн дүүргийн цахим хуудсаар нийт цаг үеийн холбогдолтой нийт 992 мэдээ мэдээлэл, 115 видео мэдээг байршуулан ажиллалаа. 2017 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлага болон Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, дүүргийн 25 жилийн ойн үйл ажиллагааг дүүргийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсуудаар шууд дамжуулан иргэд олон нийтэд хүргэн ажилласан. Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүртгэлийн хэлтэс, Газрын алба, Замын цагдаагийн хэлтсийн иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний мэдээллийг шинэчлэн засварлалаа. Мөн байгууллагын ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн цахим хуудасны	40

		баяжилтийг сайжруулах, хэлтэс албадын мэдээллийг шинэчлэх, байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл шинэчлэх ажлыг тус тус хийж ажиллалаа. Дүүргийн цахим хуудсанд дүүргийн статистикийн хураангуй мэдээлэл, байгууллагын хөдөлмөрийн аваргуудын булан, дэргэдэх хэлтэс, албадын холбоосыг цахим хуудасны нүүр хэсэгт байршуулж иргэдийн мэдээлэл авах нөхцөлийг сайжруулан ажиллалаа. Мөн дүүргийн 1-19 дүгээр хороодыг цахим хуудастай болгон дүүргийн цахим хуудсанд хороодын мэдээллийг байршуулан хороодын ажлын албаны дарга нарт сургалт зохион байгуулсан. Иргэдийг мэдээ мэдээллээр хангах ажлын хүрээнд мэдээний сайтуудаар явагдаж буй дүүргийн мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулан ажиллалаа. Дүүргийн нэгдсэн сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд 2, 3, 8, 16, 17, 18, 19 дүгээр хорооны дотоод сүлжээг цэгцлэх, байгууллагын дотоод холбоог өргөтгөх ажлын хүрээнд хэлтсүүдийн дотоод холбооны үзүүрийг тохируулан өргөтгөж ажиллалаа.	
53	5.1.3 Дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглалтын хүрээнд барилгажсан хэсэгт агаарын кабелийг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэн, сүлжээний найдвартай ажиллагааг бүрэн хангана.	Дүүргийн хэмжээнд шилэн кабелийг сувагчлалд шилжүүлэх ажлын хүрээнд агаараар явж байсан шилэн кабелийн трассыг 7 буудлаас 18 дугаар хороо хүртэл 900м газрыг сувагчлалд шилжүүлсэн. Шилэн кабелийн ашиглалтын хүрээнд дүүргийн хэмжээнд ашиглагдаж байгаа шилэн кабелийн сувагчлалын түрээсийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ компанитай гэрээгээ сунган ажилласан. Мөн дүүргийн 11, 12 хороо болон 61 дүгээр дунд сургуулийн шилэн кабелийн гэмтлийг тогтоон засварласан. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн хяналтын камерын ашиглалтын хүрээнд дүүргийн 16 дугаар хорооны хяналтын камерын шилэн кабел гэмтсэн байсныг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Дүүргийн хэмжээнд ашиглагдаж буй 1-19 дүгээр хороо болон Тамгын газар хоорондох шилэн кабелийн холболтыг ашиглан хороодын цогцолбор байруудад байрлах цагдаагийн албан хаагчдыг Цагдаагийн дотоод сүлжээнд холбох ажлыг Нийслэлийн Мэдээлэл технологийн газартай хамтран хийсэн. Мөн Дүүргийн Эрүүл Мэндийн Төвөөс Өрхийн Эрүүл мэндийн төвүүдтэй нэгдсэн нэг сүлжээнд холбогдох ажлыг Эрүүл Мэндийн Төвтэй хамтран дүүргийн шилэн кабелийг ашиглан холбож, хэвийн ажиллагаанд оруулан ажиллалаа. Мөн дүүргийн 19 дүгээр хорооны зам засварын ажлын хүрээнд шилэн кабелийг буулган дахин шинээр холбож хэвийн ажиллагаанд оруулан ажилласан.	40
54	5.1.4 Захын болон алслагдсан гэр хороололд утасгүй Wi-Fi үйлчилгээг нэвтрүүлнэ.	Дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэний танхимд утасгүй интернетийн бүс байгуулан иргэдийн мэдээлэл авах нөхцөлийг сайжруулан ажиллаж байна. Мөн дээрх хороодын цогцолбор байрны гадна орчинд 200 метрийн радиустай орчинд Нийслэлийн мэдээллийн технологийн газраас нэвтрүүлж буй Улаанбаатар Wi-Fi утасгүй интернетийн бүс байгуулах ажлыг “Бодь Электроникс” ХХК-тай хамтран дүүргийн нэгдсэн сүлжээнд өргөтгөл, шаардлагатай тохиргоог хийн амжилттай нэвтрүүлэн ажиллалаа. Улаанбаатар Wi-Fi сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд 2, 3, 4, 5, 16, 18 дугаар хорооны сүлжээнд гарсан гэмтэл, саатлыг засварлан хэвийн ажиллагаанд оруулан ажиллалаа.	40
55	5.1.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлж, зөрчил дутагдлыг шуурхай арилгадаг, заавар зөвлөмжийг тогтмол өгдөг	Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 цэцэрлэг, 3 ерөнхий боловсролын сургууль, 3 сургуулийн цайны газрыг түрээслэгч ААН, нийт 18 байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, цэцэрлэгийн хүүхдийн болон сурагчдын хоол үйлдвэрлэл, хүнсний чанарт хэмжилт, шинжилгээтэй шалгалт хийлээ. Шалгалтын явцад хүүхдийн хоолны 8 сорьц, унд ахуйн уснаас 6 сорьц, агаарын	40

<p>тогтолцоонд шилжүүлнэ.</p>	<p>ариун цэврийн 3, дотоод орчны агаарын чанарын 3, хөрсний 1 сорьц, 3 цэцэрлэгийн 30 цэгээс эрүүл зүйн арчдас шинжилгээ авч НМХГ-ын Нэгдсэн төв лаборатори шинжлүүлэн үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан. Шалгалтын хугацаанд нийт 158 зөрчил илрүүлж 38 буюу 24 хувийг шалгалтын явцад арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага 18-ыг 214 заалттай /үүнээс эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 109 заалттай/, шинжилгээний дүгнэлт 22-ыг үйлдэж 3 байгууллага, 1 албан тушаалтанд 640.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, эрүүл ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгагдсан байгууллага бүрт байгууллагын сургалтыг зохион байгуулж, бүртгэл хяналтын хөтлөлтийн загвараар хангаж ажиллалаа. Мөн дүүргийн хэсгийн болон зөөврийн усан хангамжтай 9 цэцэрлэг, 4 сургууль, төвлөрсөн усан хангамжтай 9 цэцэрлэг, нийт 22 хүүхдийн байгууллагын унд, ахуйн хэрэглээний уснаас сорьц авч НМХГ-ын НТЛ-ийн сорилтын дүнг үндэслэн улсын байцаагчийн 22 дүгнэлт үйлдсэн. Цэцэрлэгт бүртгүүлсэн хүүхдүүдийг хичээл эхлэхээс өмнө, хуваарийн дагуу цэцэрлэг дээр нь нэгдсэн журмаар эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, сургуулийн бага ангийн багш, цэцэрлэгийн багш ажиллагсдыг нэгдсэн журмаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хуваарийг гаргаж, бэлтгэл ажлыг хангуулж ажилласан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд эрсдэлтэй гэж үнэлэгдэн шалгалтанд хамрагдахаар зарлагдсан Бэтүвданжай чойнхорлон хийдийн Найдан эмнэлэг, Уран манал уламжлалт эмнэлгүүдэд Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын даргын баталсан 02-01/143 тоот удирдамжийн дагуу шалгалт хийсэн. Шалгалтаар дээрх байгууллагуудад дотоодын хяналт хангалтгүй, хувь хүний хариуцлага сул зэрэг зөрчил дутагдал илэрсэн ба тус эмнэлгүүдэд байгууллагын сургалтуудыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан 20 худалдаа, үйлчилгээний газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээс дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 14 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хяналтын хуудсаар дүгнэхэд 39.5-51 хувийн дунд болон их эрсдэлтэй дүгнэгдсэн бөгөөд, улсын байцаагчийн 125 заалттай 14 зөвлөмж хүргүүлэн, гүйцэтгэлийг хангуулан ажиллалаа. Үндэсний их баяр наадмын үеэр хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан 82 ААН, иргэнд, худалдаа үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан 27 иргэнд нийт 109 иргэн, ААН-д үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл өгч хяналт тавин ажилласан. Төв Цэнгэлдэх хүрээлэнд хяналт шалгалт хийх явцад айргийн 7 цэгээс дээж авч шинжлүүлэн, зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхэлж байсан 8 хуушуурын цэг, шорлог зарсан 3 иргэн, 3 ААН-ийн үйл ажиллагааг, 2 иргэний хөөсөн чихрийн худалдааг зогсоосон. Хүрээ цам - Даншиг наадмын үеэр 5 улсын байцаагч хяналт тавьж ажиллаж, хяналтын шалгалтын үеэр илэрсэн зөрчилгүй, олныг хамарсан хоолны хордлого, хордлогот халдвар гараагүй байна. “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг, оролцоог сайжруулах нь” сэдэвт 4 цагийн сургалтыг дүүргийн төрийн төрийн болон төрийн бус өмчийн 20 сургуулийн эмч, дотоод хяналтын ажилтан, 13 цайны газар түрээслэгч аж ахуйн нэгж байгууллагын захирал, тогооч зэрэг 75 хүнийг хамруулан зохион байгууллаа.</p>
-------------------------------	---

56	5.1.6 Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	<p>Нэг хаяганд 20-иос дээш сонгогч бүртгэлтэй, 18-аас дээш насны сонгуулийн эрх бүхий 172 иргэний нэр ерөнхий газраас ирсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 11 дүгээр хороонд бүртгэлтэй 99 иргэн, ➤ 12 дугаар хороонд 50 иргэн, ➤ 14 дүгээр хороонд 23 иргэн бүртгэлтэй байна. <p>Тус хороодын улсын бүртгэгч нарт чиглэл өгч тухайн хаягтай айлд очиж амьдардаг эсэхийг нотлох, хорооны оффлайн сүлжээ болон өрхийн хүн амын бүртгэлд байгаа эсэхийг тулган шалгах зэргээр тоог бууруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Энэ хаяган дээрээ амьдардаг-147 2.Түр эзгүй -10 иргэнийг амьдарч буй хаяг руу нь шилжүүлсэн 3.Хаяг засах-60 иргэнээс 29 иргэний хаягийг зассан 4.Огт холбоо барих боломжгүй -15 иргэн одоогоор байна. 2017 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар нэг хаяган дээр 20-оос дээш сонгогчтой 172 иргэнээс нийт 49 сонгогчийг хасаж шийдвэрлэсэн. Мөн хороодын улсын бүртгэгч нарт 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш шилжин ирсэн, явсан бүртгэлийн дэвтрийг шүүж, шилжин очих газраа бүртгүүлээгүй байгаа иргэдийн утсыг AFIS програмаас харж иргэдтэй утсаар холбогдон бүртгэлээ хийлгэхийг 320 иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Зөрчил арилгах аяны хүрээнд хорооны улсын бүртгэгч нараас дараах 4 төрлийн судалгааг авсан. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Нэг хаяган дээр бүртгэлтэй 10-аас дээш сонгогч-5901, 2. Сум, дүүргийн ИТХ-ын шийдвэрээр засаг захиргаа өөрчлөгдсөн боловч зардал шийдвэрлээгүйгээс хаяг өөрчлөгдөөгүй-0 3. Тодорхой оршин суух хаяггүйн улмаас шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй -6523 4. Төлбөрийн чадваргүй улмаас шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй-68 иргэн байна. <p>Тайлангийн хугацаанд дээрх хаягийн зөрчлийг 3099-ээр бууруулж ажилласан.</p>	40
57	5.1.7 Гэр хорооллын гудамжны хаягжилтыг эрэмбэ дараатай цэгцлэн, иргэний бүртгэлийн хаягийн зөрчил давхардлыг арилгана.	<p>Тайлант хугацаанд 3 төрлийн хаягийн зөрчлийн судалгааг нэгтгэн гаргасан. Тус судалгаанд нийт 11577 иргэнээс нэг хаяган дээр бүртгэлтэй 10-аас дээш сонгогчтой 5901, тодорхой оршин суух хаяггүйн улмаас шилжилт хөдөлгөөн хийлгээгүй 5600, төлбөрийн чадваргүйн улмаас шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй 76 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Нийт зөрчилтэй иргэдээс тухай бүр иргэдтэй холбогдон 445 иргэний хаягийн зөрчил, сүлжээнд хаяг зөрүүтэй орсон 36 иргэний мэдээллийг тус тус засварласан. Мөн харъяатаас гарсан 2 иргэнийг тухайн хороод нь офлайн бүртгэлийн программаас хасалт хийж ажиллалаа. Мөн 3, 4 дүгээр саруудад хаягийн зөрчил арилгах аяныг 19 хороодын дунд зарлан нийт 925 хаягийн зөрчил илрүүлсэнээс 601 зөрчлийг нь арилгасан. Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 1061 иргэн давхар болон хаягийн бичвэр алдаатай байсныг нэгтгэж хаягийн бичвэрийг зассан. Хаягийн зөрчил арилгах ажлын үр дүнд 9 дүгээр сарын байдлаар Нэг хаяган дээр бүртгэлтэй 10-аас дээш сонгогч 5200, тодорхой оршин суух хаяггүйн улмаас шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй 4172, бичиг баримтгүй иргэд 92 болж буурсан байна</p>	40
58	5.1.8 Батлан хамгаалах хууль	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын удирдамж, дүүргийн Засаг даргын 2017	40

	<p>тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.</p>	<p>оны А/19 дүгээр захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг зарим байгууллага, аж ахуйн нэгжид Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулан ажилласан. Шалган туслах ажлын хүрээнд төрийн 7, төрийн бус 3, нийт 10 байгууллага, аж ахуй нэгжид ажиллаж, 647 цэргийн бэлтгэл үүрэгтнийг хамруулан, 205 иргэдийн зөрчлийг илрүүлж, цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, шинээр батлагдсан Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн алба биеэр хаагаагүй иргэнд хуулийн дагуу мөнгөн төлбөр тогтоож нийт 124.0 сая төгрөгийг нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/144 дүгээр тушаал, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын 2017 оны 11 дүгээр тушаалын дагуу зохион байгуулсан Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах Батлан хамгаалах яамны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Баянгол, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын цэргийн штабуудтай хамтран оролцсон. Өдөрлөгийн үеэр 6 иргэнд цэргийн үүрэгтний үнэмлэх шинээр нээн олгож, 71 иргэнд Батлан хамгаалах багц хуулийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үндэсний Батлан Хамгаалах Их сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдаж, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, эцэг эх, хүүхэд, залуучуудын төлөөлөл оролцлоо. Өдөрлөгийн үеэр 2017 оны хоёрдугаар ээлжээр татагдан очсон шинэ дайчдын цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаа болж, Үндэсний Батлан Хамгаалах Их сургуулийн Аюулгүй байдлын сургууль, Цэргийн нэгдсэн сургууль, Ахлагчийн сургуулиудын сургалт, үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгааны ажил явуулж, элсэн суралцах хүсэл сонирхолтой сурагч, эцэг эхийн төлөөлөлд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан юм. Цэргийн штаб нь ой болон үйл ажиллагааныхаа хүрээнд зохион байгуулсан ажлуудаа нийслэл, дүүргийн цахим хуудсанд болон “MN-25”, “ТВ-5”, “ТВ-8”, “ЕТВ”, UBS, “Эх орон”, ТМ, МНС, БХЯ-ны “Дуулга” зэрэг мэдээллийн хэрэгслүүдээр мэдээ, сурвалжлага өгч Батлан хамгаалах бодлого, шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг сурталчлан ажилласан.</p>	
<p>59</p>	<p>5.1.9 Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлт, удирдлагын нэгдмэл байдлыг ханган ажиллана.</p>	<p>Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/49 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/71 дүгээр тушаалын дагуу хороодын Засаг дарга, Ажлын албаны дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгууллаа. 2017 оны 03-р сарын 28-ны 07.00 цагт дадлагын дохио өгч Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд бүрэн цугларч, ЗДТГ-ын дарга А.Дамцагдорж сургалтыг чанартай, аюул осолгүй зохион байгуулах талаар үүрэг даалгавраар хангаж, сургалтанд хороодын Засаг дарга нар бүрэн хамрагдсан. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн харьяа “Ар сайхан” авто сургуультай хамтран 10 бэлтгэл үүрэгтнийг жолооны В-С ангилал ахиулах, “ТЕЛЕФОНЧИН” мэргэжлээр 15 бэлтгэл үүрэгтнийг Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн тус тус 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсан. Сургалтад хамрагдсан бэлтгэл үүрэгтнүүдийг анги командуудад оногдуулан дансалсан. Бэлтгэл офицерийн сургалтыг ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн явуулж, дүүргийн</p>	<p>40</p>

		<p>Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга О.Нямбат Мэдээлэл технологи олон нийттэй харилцах албаны дарга Б.Лхагваням нар сургалтад хамрагдсан. Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнийг анги командад оногдуулан дансалсан. Цэргийн дүйцүүлэх алба хаагчид цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн анхан шатны сургалт бэлтгэлийг Налайх дүүрэг дэх Зэвсэгт хүчний 350 дугаар явагдсан. Сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийн дагуу 5 төрлийн хичээл, лекц-40 цаг, дадлага-76 цаг нийт 116 цагийн хичээл сургалт тасралтгүй явуулсан. Тус сургалтад дүүргийн дүйцүүлэх албыг хааж байгаа 8 албан хаагч, хоёрдугаар зэргийн 10 бэлтгэл үүрэгтэн нийт 18 иргэн хамрагдсан. 2017 онд явагдах “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутнуудын судалгааг гаргуулан, эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад хамруулан, 7 сургуулийн 34 оюутныг ҮБХИС-д хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Засаг даргын А/186 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн Засаг даргын 2017 оны А/206 дугаар захирамжийг гарган батлуулж, 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/679, дүүргийн Засаг даргын А/606 дугаар тоот захирамжуудыг тус тус үндэслэн хоёрдугаар ээлжийн цэрэг татлага, цэргийн гэрээт албанд элсүүлэх ажлыг 2017 оны 10 дугаар сарын 20-оос 22-ны өдрүүдэд цэрэг татлагын байранд тус тус зохион байгуулж Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас өгсөн хяналтын тоог бүрэн биелүүлсэн.</p>	
5.2 ГЭМТ ХЭРЭГ, ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ			
60	<p>5.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, үйлдэгдэж буй гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бууруулна.</p>	<p>Нийтийн хэв журам хамгаалах тасгаас нийт 221 удаагийн хамгаалалт зохион байгуулагдсан ба давхардсан тоогоор 1795 хүн 9700 цаг үүрэг гүйцэтгэж ажилласан. Үүнээс дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс үүрэг гүйцэтгэж буй эргүүлийн 8 авто машинд 88 алба хаагч 86859 цаг үүрэг гүйцэтгэсэн. Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарч “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулж, шинээр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн хүчирхийллийн талаар “Хамтарсан баг” гишүүдийн үйл ажиллагааны нэгдсэн зорилго чиглэлтэй болох, гэмт хэргээс удьчилан сэргийлэх ажилд оролцох үйл ажиллагааны талаар 125 хүнд сургалт зохион байгуулсан. Шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу Олон нийтийн цагдаа нарт мэргэжил арга зүйн зөвлөмж, ажлын чиглэл, зааварчилгааг нийт 31 удаа өгч хичээл, сургалтанд 6 удаа хамруулан үйл ажиллагааг нь дэмжиж ажилласан. Дүүргийн 1-19 дүгээр хороодод 2012 онд “Сектек” ХХК-ий суурилуулсан 40 ширхэг, 2016 онд “Нью Фалкон” ХХК-ий суурилуулсан 365 ширхэг хяналтын камеруудад урсгал засвар, үйлчилгээг хийж дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтсүүд хяналтын камерын ашиглалт, үйлчилгээнд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна. Цаашид телекамерын тоог нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын тамгын газраас хөрөнгийг шийдвэрлэн хариуцсан хороодын нутаг дэвсгэрт 85 ширхэг, Зуслан орчмын бүсэд 25, нийт 110 ширхэгийг нэмж байрлуулхаар ажиллаж байна. Мөн ирэх 2018 онд Цагдаагийн ерөнхий газраас 90 цэгийн 103 камерыг суурилуулахаар судлагааг хийж ажиллаж байна.</p>	40
61	<p>5.2.2 Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай</p>	<p>Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангах ажлын хүрээнд Замын цагдаагийн хэлтсийн үүдний хэсгийн засварыг 9,8 сая төгрөгөөр “Хүрээ өргөө” ХХК, мөн тус хэлтсийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 36,8 сая төгрөгөөр “Голден прогресс” ХХК,</p>	40

	техник хэрэгслээр хангана.	дүүргийн прокурорын газарт автомашин нийлүүлэх ажлыг 60,0 сая төгрөгөөр Монгол Хьюндай автмотив” ХХК, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлыг 49,5 сая төгрөгөөр “Эф Эй Ди” ХХК, Цагдаагийн 2 дугаар хэлтсийн материаллаг баазыг бэхжүүлэх техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 49,9 сая төгрөгөөр “Тольт хөдөлгүүр” ХХК, цагдаагийн 1 дүгээр хэлтэст шаардлагатай техник хэрэгсэл нийлүүлэх ажлыг “Халиун проперти” ХХК, Мэдээллийн гэрэлт самбар байрлуулах ажлыг “Би би икс ээл” ХХК хийж гүйцэтгэсэн. Цагдаагийн 1,2 дугаар дүгээр хэлтсүүдэд гэмт хэрэг, зөрчил гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэрч, хохирогч, насанд хүрээгүй иргэдээс тайлбар мэдүүлэг авах, таньж олуулах ажиллагаа явуулах байцаалтын өрөөг “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулсан.	
62	5.2.3 Замын хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгож, зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулна.	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнийг оновчтой зөв зохион байгуулах, хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах, жолооч, явган зорчигч нарт замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийн захиалгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Замын цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтэс, Нийслэлийн Автозамын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газарт тус тус хүргүүлж ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарч Дүүргийн 19 дүгээр хороо “Яргайтын богино” зуслангийн асфальтан хучилттай 2,5 км, 12 дугаар хороо Гахайн байрнаас хойшоо Хайлаастыг холбосон 1,6 км асфальтан хучилттай болон ЭКО чулуун хучилттай 1,5 км, Дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтарч 7, 9, 10, 11, 16, 17, 18, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 8,7 км буюу нийт 14,3 км автозамыг шинээр ашиглалтад оруулсан. Шаардлагатай гудамж замуудад явган зорчигчийг гарцгүй хэсгээр зам хөндлөн гарахаас урьдчилан сэргийлж, зорчих хэсгийн голоор хайс байрлуулах саналыг Нийслэлийн автозамын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газарт хүргүүлснээр, дүүргийн 6 хороо Их тойруу, Баянбүрийн аюулгүйн тойргийн зүүн замд 100 метр, 1 дүгээр хороо Хэрэг бүртгэх албаны урд замд 200 метр, 2 дугаар хороо их тойруу, “Бөмбөгөр” худалдааны төвийн баруун замд 30 метр, 5 дугаар хороо Самбуугийн гудамжинд 60 метр, Хувьсгалын замд 50 метр, Галданбошигтын гудамж, 39 дүгээр сургуулийн зүүн замд 30 метр нийт 470 метр хайсыг зорчих хэсгийн голоор байрлуулсан. Замын тэмдэг шинээр байрлуулах саналыг Нийслэлийн Автозамын хөгжлийн газарт хүргүүлж нийт 475 ширхэг тэмдэг шинээр болон нөхөж байрлуулсан. Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтарч Энхтайваны өргөн чөлөө, Бага тойруу, Самбуугийн гудамж, Их тойруу, Галданбошигтын гудамж, Хайлаастын зам, Энэбишийн өргөн чөлөө, Хувьсгалын замуудын эгнээ хязгаарлах хэвтээ тэмдэглэлийг будаж тодруулсан. Дүүргийн тохижилт үйлчилгээний кампани, Хот тохижилтын газартай хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт зам, замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүссэн хэсэгт 450 тонн давс, бодис цацуулж зам тээврийн хэрэг, осол гархаас урьдчилан сэргийлж ажилласан. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, зөрчлийн илрүүлэлтийг ахиулах зорилгоор Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Хүүхэд аюулгүй орчин”, “Улсын дугаар зэрэг 21 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион явуулж 3331 хүнийг 68.956.200 төгрөгний торгуулийн шийтгэл ногдуулж, зөрчил арилгах талаар 29 иргэн аж ахуй нэгж байгууллагад албан</p>	40

		<p>мэдэгдэл шаардлага өгч ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт 2016, 2017 онд зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон, гэмтсэн ослын шалтаан нөхцөлийн судалгаанд үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт “Зуслан хяналт-шалгалт”, “Зогсолт зогсоол-дэг журам”, “Хурд” зэрэг хэсэгчилсэн 8 арга хэмжээг зохион явуулж цагдаагийн нийтлэг үүргээр 51, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 42, зөрчил гаргасан 1525 хүнийг 41,175,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, зөрчлийн илрүүлэлтийг ахиулах зорилгоор зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үр дүнг энэ оны эхний 10 сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд, зөрчлийн илрүүлэлт 89304 буюу 46,1%-иар, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 2275 буюу 14,7%-иар тус тус өссөн, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 35,2%-иар, зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон хэрэг 2016 онд 10, 2017 онд 10 буюу 0%-иар, гэмтсэн хүн 39,5%-иар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 42,6%-иар тус тус буурсан үр дүн гарсан байна. Дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнийг оновчтой зөв зохион байгуулах жолооч явган зорчигч нарт замын хөдөлгөөнд оролцоход зөв мэдээлэл өгөх зорилгоор 2017 оны байдлаар нийслэлийн хөрөнгөөр 15 байршилд 400, дүүргийн хөрөнгөөр 23 байршилд 475 хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг шинээр байршуулсан.</p>	
63	5.2.4 Дүүргийн гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	<p>Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гамшгийн нөөц бүрдүүлэхэд зориулж 40,0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс тайлант хугацаанд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/240 дүгээр захирамжаар 25.141.800 төгрөг, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай А/220 тоот захирамжаар 3.041.380 төгрөг Бэлэн байдлыг хангах тухай А/104 тоот захирамжаар 11.699.00 төгрөг, Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, эргүүл, хяналт шалгалт хийх тухай А/530 тоот захирамжаар 3.198.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргаж нийт 4 захирамжаар 43.179.180 төгрөгийг шийдвэрлэж зарцуулаад байна. Дүүргийн нутаг дэвсгэрт “Нарийн болон мухар гудамжны судалгаа”, “Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын зурваст суурьшсан иргэн аж ахуйн нэгж байгууллагын судалгаа” явуулахад гэр хорооллын хороодын 179 айл өрх мухар гудамжтай байна. Эдгээр айл өрхүүдээс нүүлгэн шилжүүлэх нэн шаардлагатай 5 өрхөд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл бичиж хүргүүлсэн.</p>	40
64	5.2.5 Дүүргийн нутаг дэвсгэрт “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	<p>Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2017 оны 30 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эрсдэлийг бууруулах, төрийн болон мэргэжлийн байгууллагуудаас гадна хувийн хэвшил, төрийн бус байгууллага, сайн дурын олон нийтийн байгууллага иргэдийн оролцоог гамшгаас хамгаалах ажиллагаанд татан оролцуулах зорилготой “Аюулгүй хороо” нэгдсэн сургалт өдөрлөгийг 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж, Онцгой байдлын хэлтсээс 5 офицер, 58 ахлагч, 4 автомашинтайгаар, дүүргийн Гамшгаас хамгаалал сайн дурын хэсгээс 4 албан хаагч, Эрүүл мэндийн төвийн 3 эмч, УБЦТС ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвөөс 6 ажилтан, 19 дүгээр хорооны</p>	40

	ажлын албаны 18 албан хаагч, нийтийн эргүүл 29 ажилтан нийт 125 хүн хамрагдсан. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжаар сайн дурын хэсэг байгуулагдаж үйл ажиллагаа тогтмолжсон байна. Одоогийн байдлаар сайн дурын хэсэг нь хэсгийн ахлагч 1, сайн дурын 5 ажилтан нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй үүрэг гүйцэтгэж байна.	
--	--	--

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР